

УЛС ТӨР

⊖ НДШ, ХХОАТ-ын хөнгөлөлт төсвөөс цалинждаг байгууллагынханд үйлчлэхгүй → 2

ЭДИЙН ЗАСАГ

⊖ Ноолуурын үнийг яам биш зах зээл тодорхойлно → 9

ЭДИЙН ЗАСАГ

⊖ Хямралын эсрэг арга хэмжээ авах нь зөв ч ирэх жилүүдэд анхаарсан эдийн засгийн бодлого чухал → 10

ZGM DAILY

⊖ FULL ENGLISH PAGE INSIDE → 20-21

# ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ

TDB ONLINE  
Банкны бүх төрлийн үйлчилгээг нэг дороос

2020.04.02, ПҮРЭВ-№052 (1331)

~ ИРГЭН БАЯН БОЛ УЛС БАЯН ~

₮1000, 24 НҮҮР

АЛТ 1,606.50 0.62%	ЗЭС 4,951.00 3.81%	ТӨМРИЙН ХҮДЭР 600.00 0.00%	НЕФТЬ 46.83 23.30%	ЧИНГИС БОНД 102.56	ХУРАЛДАЙ БОНД 108.18	ГЭРЭГЭ БОНД 102.38	САМУРАЙ БОНД 103.39	АМ.ДОЛЛАР 2776.98	ЮАНЬ 390.89	РУБЛЬ 35.08	ВОН 2.25
--------------------------	--------------------------	----------------------------------	--------------------------	-----------------------	-------------------------	-----------------------	------------------------	----------------------	----------------	----------------	-------------

## ЧӨДРИЙН ГАНЦАА АВРАХ УУ, АЛДАХ УУ ГЭДГЭЭ ЭЗЭН НЬ МЭДЭЖ ДЭЭ



⊖ Олон улсын Агаарын тээвэр-лэгчдийн холбооноос (IATA) дэлхийн улс орнуудын Засгийн газарт хандаж, агаарын тээврийн компаниуддаа боломжоороо тусалж, дэмжихийг уриаллаа. Энэ уриалга нь Монголын Засгийн газарт ч хамаатай.

Гэрэл зургийг С.Батсайхан

→ 5

⊖ **Коронавирусийн монголчуудад өгсөн "хичээл"**

→ 4

"Юм яаж ч муудсан сайжрах талруугаа явж байдаг" гэх үг биелэлээ олно.

⊖ **Салхи ихтэй Улаанбаатарт дүүжин тээвэр тохиромжгүй**

→ 7



⊖ **Засгийн газарт хоёр сонголт байна**

"Эрдэнэс Тавантолгой"-н ногдол ашгийн дийлэнхийг төр хамна.

→ 8



#348 \$5.85 тэрбум



**Роберт Нг,**  
Sino Group-ийн захирал,  
Сингапурын тэрбумтан

**Ямар нэг үнэт зүйл, хэтийн зорилгогүйгээр эд хөрөнгөд тэмүүлсэн хүн түүндээ эзэмдүүлж дуусдаг.**

Өнөөдөр -5°C ☁	Маргааш -3°C ☁
-12°C 🌙	-16°C 🌙



Э.Долгион



### ӨДӨР ТУТМЫН СОНИНУУДЫН ХОЛБООНЫ ЕРӨНХИЙЛӨГЧӨӨР Э.ДОЛГИОНЫГ УЛИРААЖ, Б.БАЯРМАГНАЙГ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛААР ТОМИЛЛОО

Монголын "Өдөр тутмын сонинуудын холбоо" ТББ-ын ээлжит хурал өчигдөр цахимаар хуралдлаа. Тус хурлаас "Өдөр тутмын сонинуудын холбоо"-ны Ерөнхийлөгчөөр "Засгийн газрын мэдээ" сонины ТУЗ-ийн дарга Э.Долгионыг улируулан сонгож, "Өнөөдөр" сонины Ерөнхий менежер Б.Баярмагнайг тус холбооны өдөр тутмын үйл ажиллагаа хариуцсан Гүйцэтгэх захирлаар томилсон шийдвэр гаргалаа. Мөн Монгол Улсын СГЗ, "Монголын үнэн" сонины Ерөнхий эрхлэгч Б.Ганболд тус холбооны Хүндэт ерөнхийлөгчөөр сонгогдсон байна. "Өдөр тутмын сонинуудын холбоо" нь Дэлхийн сонины холбоонд Монголын хэвлэл мэдээллийн байгууллагуудыг төлөөлсөн албан ёсны гишүүн байгууллага юм.



Б.Баярмагнай

## УЛС ТӨР

## ЗГМ: ТОВЧХОН

## ■ ТОО

0

Хувь. ОУВС дэлхийн эдийн засгийн өсөлтийг тэг, БНХАУ-ын эдийн засгийг хоёр хувь өснө гэж тооцжээ.

## ■ ТАТВАР

47

Мянган төгрөг. 2020 оны эхний улирлын НӨАТ-ын буцаан олголтыг энэ сард багтаан олгоно. Нийт 860 мянган иргэн энэ буцаалтыг авах бөгөөд дунджаар нэг иргэн 47 мянган төгрөгийг буцааж олгох аж.

## ■ ШҮҮХ

Сүхбаатар дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд шүүгдэгч Б.Махбалд холбогдох эрүүгийн хэргийн шүүх хуралдаан товлогдсон байсан юм. Гэвч Б.Махбалын өмгөөлөгчийн хүсэлтээр уг хуралдааныг хойшуулав. Түүнээс гадна шүүгчдэгч Б.Махбал нь нэмж өмгөөлөгч авсан тул, хэргийн материалтай танилцах шаардлагатай гэсэн байна. Хэргийг сануулбал ЗТХЯ-ны газрын дарга нар албан байгууллага дээр архи дан согтуурч, нэгийнхээ амийг хөнөөсөн ноцтой хэрэг 2018 оны наймдугаар сард гарсан билээ.

## ЗАСГИЙН ГАЗАР

# НДШ, ХХОАТ-ЫН ХӨНГӨЛӨЛТ ТӨСВӨӨС ЦАЛИНЖДАГ БАЙГУУЛЛАГЫНХАНД ҮЙЛЧЛЭХГҮЙ

Улсын төсвийн орлого төлөвлөж байснаас 97.8 тэрбум төгрөгөөр байдлаар дутуу орж ирсэн

✍ Б.Энхжаргал, ЗГМ сонин

**К**оронавирусийн улмаас эдийн засагт үүсэж буй хямралын эсрэг Засгийн газрын авч буй арга хэмжээнүүдийн талаар Сангийн сайд Ч.Хүрэлбаатар нэмэлт, мэдээллийг өглөө.

Өчигдрийн байдлаар нийт 17 тэрбум төгрөгийг дотоодыг эх үүсвэрийн уг вирусээс урьдчилан сэргийлэх болон эрүүл мэндийн арга хэмжээнд зарцуулжээ. Тодруулбал, эмнэлгийн тоног төхөөрөмж, эм хангамж хамгаалах хэрэгсэлд өсөн тэрбум, халдваргүйжүүлэлт, ариутгал бусад зардалд 6.5 тэрбум төгрөг, нэмэлт цалин хөлс, томилолт 1.5 тэрбум төгрөг олгосон байна. Харин гадаадын зээл тусламж, хандивыг оролцуулаад нийт 200 тэрбум төгрөгийг эрүүл мэндийн салбарт зарцуулсан аж.

Харин эдийн засгийн хямралын эсрэг Засгийн газраас шийдвэрлэсэн зарим хариу арга хэмжээг нэмж тайлбарлав. **Тухайлбал, нийгмийн даатгалын шимтгэл, ХХОАТ-ыг энэ сараас ирэх аравдугаар сарын 1 хүртэл тэглэсэн шийдвэрт**



Гэрэл зургийг С.Батсайхан

**зарим төрлийн байгууллагын ажилтнууд хамрагдахгүй юм. Тухайлбал, төрийн бүх албан хаагч, төрийн өмчит компанийн ажилтнууд, төрөөс тендер авч ажил гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгжийн ажилтнууд энэ хөнгөлөлтийг эдлэхгүй.** Яагаад гэвэл корона вирусийн нөлөө улсын төсөв одоохондоо дарамт болоогүй гэж үзэж байгаа аж. Мөн орлого нь буураагүй аж ахуйн нэгж энэ хөнгөлөлтөд

хамаарахгүй юм.

Улсын төсвийн орлого эхний улирлын байдлаар төлөвлөж байснаас 97.8 тэрбум төгрөг дутуу орж ирсэн. Энэ цаашид үргэлжлэх төлөвтэй байна. Сангийн яам хоёрдугаар сараас тэвчиж болох зардлуудаа танихсан байсан. Экспортын хэмжээ 560 сая ам.доллар, импорт 150 сая ам.доллараар буураад байна. Тиймээс эдийн засгийг идэвхжүүлэх хүрээнд экспортыг

нэмэгдүүлэх ажлыг салбар яамд идэвхтэй өрнүүлж байна" гэж Сангийн сайд мэдэгдэв.

Түүнээс гадна нийгмийн даатгалын шимтгэл төлдөг даатгуулагчдад Ажилгүйдлийн даатгалын сангаас сар бүр 200 мянган төгрөг олгоно. Түүнчлэн үйл ажиллагаа нь төрийн шийдвэрээр зогсоосон боловч ажлын байраа хадгалсан ААН-үүдийн ажилтнуудад мөн сар бүр 200 мянган төгрөг олгох юм. ■

## ЗГМ: ТОДРУУЛГА

## Д.Лүндээжанцан: Маш олон хууль хүлээгдэж буй тул парламент ямар нэгэн байдлаар хуралдах ёстой

Цаашид ч ийм өвчин гарах, газар хөдлөлт, янз бүрийн байгалийн гамшиг юу ч тохиолдож болно

✍ Б.Сэлэнгэ, ЗГМ сонин

УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд цахим хуралдааны дэгийг тогтоосон нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл дээр ажиллаж буй УИХ-ын гишүүн Д.Лүндээжанцангаас зарим зүйлийг тодрууллаа.

**-УИХ-ын намрын чуулганыг онлайн аргаар хийх зохион байгуулалтыг Тамгын газраас хийж байна. Онлайн аргаар хуралдуулах боломж бий юу?**

-УИХ-ын хуралдааны танхимд

хуралдаан даргалагч, зөвлөлийн гишүүд, байнгын хороон дарга нар байх ёстой. Том зааланд 10 гаруй хүн тараад суухад аюулгүй. Нэг хэсэг нь Жанжин-сүхбаатарын танхим, Их эзэн чингис хааны танхим, В, Г танхим гээд тоноглогдсон дөрвөн зааландаа цөөн цөөнөөр суун, хуралдаж болно. Мөн зарим нь өрөөнөөсөө хуралдаанд оролцох юм.

**-Тоног төхөөрөмжийн хувьд бэлтгэл ажлыг хангасан болов уу?**

-Би хууль санаачлагчийн хувьд

Тамгын газарт шаардлага тавьж байгаа. Тагнуул, технологийн байгууллагуудтай хамтран ажиллаад, техникийн тестүүдээ өнөөдрөөс хийж байна. Нэг дор сууж байгаа юм шиг хуралдана. Бразиль улсын парламент мөн энэ маягаар хуралдаад эхэллээ. Маш олон хууль хүлээгдэж байна. Тиймээс ямар нэгэн байдлаар парламент хуралдах хэрэгтэй. Засгийн газраас эдийн засгийн хүндрэл бэрхшээлтэй холбоотой 10 гаруй асуудал орж ирж байна. Үүнийг бид яаралтай хэлэлцэх шаардлагатай. Тиймээс

цахим хуралдааны дэг гэдгийг гаргаж, нэвтрүүлэхээс аргагүй юм.

**-Хэсэг хугацаанд ийм дэгээр явах уу?**

-Түр гэж ойлгож болохгүй. Олон улсын хөл хорионы нөхцөл байдал арилахаар ердийн журмаараа явна. Гэхдээ үүнийг аравдугаар сарын 1 гэж хугацаа зааж болохгүй. Цаашдаа ч ийм өвчин гарах, газар хөдлөлт, янз бүрийн байгалийн гамшиг тохиолдохыг үгүйсгэхгүй. Тиймээс онц байдлын үед, дайн самуун, олон улсын хөл хориот дэглэмийн үед

хуралддаг дэг байх ёстой. УИХ-ын хуралдааны дэгийн хуульд давхар суулгах ёстой юм.

**-Тавдугаар сарын 25-нд шинэ Үндсэн хууль хэрэгжиж эхэлнэ. Үүнээс өмнө дагаж гарах хуулиудад өөрчлөлт оруулж амжих уу. Амжихгүй бол яах вэ?**

-Бүх хуульд өөрчлөлт оруулж чадахгүй. Тиймээс хуучин хуулиар явна. Шүүхийн хуулийг хэлэлцээд баталлаа гэхэд хэрэгжих хугацааг аравдугаар сар, нэгдүгээр сараас гэж тавьж болно. Гол заалтууд сонгуулийн дараа хэрэгжинэ. ■



# THE NU ХАМТЛАГИЙНХАН ХӨЛ ХОРИОГ ҮР БҮТЭЭЛТЭЙ ӨНГӨРӨӨЖ БАЙНА

Бид Австралид шинэ хөгжим зохиох, бичлэг хийхэд ихэнх цагаа зарцуулж байна гэв

Б.Энхжин, ЗГМ сонин

Дэлхийг байлдан дагуулж буй The Nu хамтлагийнхан Австралид аялан тоглолт хийж явахдаа хорионд орсон. Коронавирусийн халдвар тэдний аялан тоглолтыг нураагаад зогсохгүй эх орондоо ирэх боломжийг нь хязгаарласан хэрэг. Гэхдээ хамтлагийн залуус хориог үр дүнтэй ашиглаж,

шинэ уран бүтээлдээ ханцуй шамлан оржээ. Тодруулбал, Сидней хотын нэгэн студид өөрсдөд нь итгэмээргүй амжилт авчирсан “Гэрэг” цомогтоо шинэ дуу нэмэхээр ажиллаж байгаа аж. Тэд саяхан **Star Wars Jedi: Fallen Order** тоглоомонд зориулан **Sugaan Essena** гэх дуу гаргасан. Хамтлагийнхан цаашид ч **Star Wars** төсөлтэй хамтран ажиллахаа мэдэгджээ. Тус хамтлагийн залуус Британийн

хөгжмийн сайт NME-д өгсөн ярилцлагадаа “Бид дуу хөгжим, дайчин эрэмгий чанараараа нэгдсэн ах дүүс. Хүнд хэцүү энэ цаг үед бие биенээ өдөр бүр дэмжиж, хөгжихийн тулд чадах бүхнээ хийж байгаа. Бид Австралид шинэ хөгжим зохиох, бичлэг хийхэд ихэнх цагаа зарцуулж байна. Дараагийн цомгийн ажилдаа хэдийн орсон. Мөн Lukas Film-ийн төсөлтэй холбоотой зарим нууц ажлууд ч хийж байгаа” хэмээн ярьжээ. ■

## О.Хангай харцага “Эрүүл ирээдүй” аянд уриалав

Улсын харцага О.Хангай үр хүүхдүүдээ ирээдүйд хорт утаанаас хамгаалахын төлөө хандивын аян зарлалаа. Тэрбээр “Эрүүл ирээдүй” хандивын аяны хүрээнд сургууль, цэцэрлэг, асрамжийн газруудад агаар шүүгч бэлэглэх юм. “Би өөрөө аав хүн. Нэг хүүхдийг ч гэсэн цэвэр агаараар амьсгалуулж, нэг хүүхдэд ч гэсэн цэвэр агаар бэлэглэх үүднээс энэ аяныг эхлүүлсэн юм. Агаар шүүгч янз бүрийн үнэтэй юм билээ. Би өмнө нь барилдааныхаа бай

шагналаас хэд хэдэн газарт 990 мянган төгрөгийн үнэтэй агаар шүүгч авч өгсөн. **Бид заавал төрийг хараад суух биш, нийгмийн хариуцлагынхаа хүрээнд бага ч гэсэн зүйл хийхийг хүссэн юм.** Эхний ээлжинд хаана хандивлахаа судалж байна” хэмээн ярилаа. Түүний санаачилгыг цөөнгүй бөх дэмжиж буйгаа илэрхийлж, хандивын аянд нэгдэхээ илэрхийлээд байна.

Хандивын данс: Хаан банк, 5131145453, Оргих Хангай ■


## Б.Махбалыг шүүх хурал хойшлов



Сүхбаатар дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд Б.Махбалд холбогдох эрүүгийн хэргийн шүүх хуралдаан өчигдөр эхэлсэн ч **өмгөөлөгчийн хүсэлтээр дөрөвдүгээр сарын 20-ныг хүртэл хойшлууллаа.** Шүүгдэгч өмгөөлөгчөө нэмсэн бөгөөд уг өмгөөлөгч хэргийн материалтай танилцах

хүсэлт гаргаж, мөн шүүх хуралдаанд шинжээч эмч оролцуулах хүсэлт өгсөн нь хойшлуулах үндэс болжээ. Нийслэлийн прокурорын газраас Б.Махбалыг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 10.1 дүгээр зүйлийн 2.1 дэх хэсэгт заасан “Онц харгис хэрцгийгээр хүнийг алах” гэмт хэрэгт яллаж, шүүхэд шилжүүлсэн юм. ■

## ХЭР ИХИЙГ УНШИХ НЬ БУС ЮУГ СОНГОЖ УНШИХ НЬ ЧУХАЛ



НӨХӨРСӨГ ФОРМАТ - АЖИЛ ХЭРЭГЧ НИЙТЛЭЛИЙН БОДЛОГО - ОЛОН ТАЛЫН МЭДЭЭЛЭЛ



Та QR кодыг уншуулан гүйлгээний утга хэсэгт и-мэйл хаяг, утасны дугаараа бүртгүүлж, “Засгийн газрын мэдээ” сониныг захиалаарай.

www.zgm.mn  
Утас: 70103131

✎ Б.Гарьд, ЗГМ сонин

“Юм яаж ч муудсан сайжрах талруугаа явж байдаг” гэх үгийг дэлхийн утга зохиолын сод туурвилуудын нэг “Эрэлхэг цэрэг Швейк” зохиолд өгүүлсэн байдаг. Чехийн алдарт зохиолч Ярослав Хашекийн амьдралын хүнд хэцүү ямар ч тохиолдолд сэтгэлээр унаж гуньж гутардаггүй, үргэлж болно, бүтнэ гэсэн гэгээлэг үзлээр хорвоог харж буй цэрэг Швейкээр дамжуулан нийгмийн сэтгэлзүй, хүний мөн чанарыг өөрчилж болохыг харуулсан бүтээл юм. Үүний адил монголчуудад коронавирус түвэг удаж байгаа ч нийгмийн сэтгэлзүйг сайн талруу өөрчилж буй олон жишээ байна.

**Коронавирус монголчуудад олон зүйлийг ойлгуулж, олон сайн дадал сургаж байгаа нь өдөр бүр анзаарагдах боллоо. Ялангуяа хувийн ариун цэврээр маруухан байсан нийтлэг жишиг арилж, монгол хүн дор бүрнээ гараа угааж сурсан нь нийтийг хамарсан эрүүл ахуйн “кампанит ажил” болов. Өмнө нь гэртээ ороод гараа угаадаггүй хүн олон байсан гэдэг эргэлзээгүй. Гадуур хооллохдоо ч гарын ариун цэврийг ингэж их чухалчилдаг байсан гэж үү. Бие зассаны дараа гараа эрх биш угаадгийг эс тооцвол үндсэндээ бид заваан үндэстэн байжээ. Харин одоо байдал эрс өөрчлөгдөж гарсан, орсон тоолонгоор, хооллох бүртээ гараа угааж сурч буй нь коронавирусийн ач тус гэх нь юу юм. Гэхдээ сайн сургамж зөв дадал боллоо. Мөн гудамж талбайд ил задгай шүлс, ялгадсаа хаяж явдаг бүдүүлэг монголчуудын тухай гаднынхан баримтат кино хүртэл, монгол тамирчны “байгаа оносон” нулималтын талаар япончууд жигшин шагшдаг цаг өнгөрсөнд үлдэж байгаа нь сайшаалтай. Хэдэн жилийн турш гудамж талбайг бохирдуулж байсан явдал үгүй болж цэвэр, эрүүл орчинд амьдрах боломж ч нэгээр нэмэгдлээ. Энэ бас яах аргагүй коронавирусын “ач тус” юм.**

Үүнээс гадна чөлөөтэй сэлгүүлцэх эрх чөлөө хумигдсан ч хувийн эрх чөлөөнд халддаг байдлыг ч титэмт вирусийн “ачаар” халж байна. Хэдхэн сарын өмнөх бэлэн мөнгөний машинд хэрхэн дугаарладаг үзэгдлийг өнөөдрийнхтэй харьцуулахад л хувийн эрх чөлөө илүүтэй мэдрэгдэнэ. Хойноос тэврэх нь холгүй, нууц үг хулгайлах гэж



## Коронавирусийн монголчуудад өгсөн “хичээл”

“Юм яаж ч муудсан сайжрах талруугаа явж байдаг” гэх үг биелэлээ олно

байгаа юм шиг мэдрэмжийг төрүүлдэг байсан бол өнөөдөр миний орон зайд бусдын “нүд бэлчихгүй” сайхан жишиг ч тогтож байна. Өвчин тусахаас айсандаа бус бусдын биед халдах, хувийн орон зайд нэвтэрч байснаа ойлгосон гэдэгт эргэлзэхгүй байна.

Түүнчлэн миний эрх хүний эрхээр хязгаарлагддаг ардчилсан нийгмийн үнэт зарчим ч бодит утгаараа хэрэгжих нөхцөл бүрдэж эхэллээ. **Үг авдаггүй, хэдэрлэдэг монгол залуус бусдын шаардлагыг биелүүлдэг, дутагдлаасаа**

**ичиж, эмээдэг болсон нь сайны ерөөл шүү. Макскаа зүүгээгүй нэгэндээ шаардлага тавих нь хэнээ, сүржигнэл биш өөрийнх нь хийгээд нийтийн төлөө гэдгийг ухамсарлаж байгаа нь бас л нэг сайн чанар. Нэг хүний хариуцлагагүй явдал бусдад их хохирол учруулж болохыг франц эрийн явдлаас баттай мэдэж авсан бид саяхан Баян-Өлгий дэх тусгаарлалтаас оргосон эмэгтэйг “барьж идэхээ” шахсан нь үүний нотолгоо. Өөрөөр хэлбэл нэг нь нийтийн төлөө гэх нийгэм**

хамгаалалын системийн ашиг тусыг ойлгож эхэлж байна.

**Коронавирус нийгмийн сэтгэлзүйг сайжрах талруу нь чиглүүлсний зэрэгцээ монгол үндэстний үнэлэмжийг дэлхий нийтэд өргөсөн нь сайнаар барахгүй ашигтай нөхцлийг “бэлэглэлээ”.** Саяхны нэг жишээ дурдахад Испанид амьдардаг монгол залуу хүнсээ цуглуулахаар гарахад ази гэдгээр гадуурхаж, элдэв ааш гаргаж байсан бол маргааш нь монгол дээлээ өмсөн, алтан соёмботой маск зүүгээд л испаничуудын хүндлэлийг олсон талаараа цахим хуудастаа нийтэлжээ. Энэ бол дэлхий нийт монгол үндэстнийг бусдаас сайнаар үздэг болсны нэг жишээ юм. Монгол хүний

өвчин тэсвэрлэх чадварыг дагаад хэрэглэдэг хоол, хүнс нь ч олон орны иргэдийн сонирхлыг зүй ёсоор татаж байгаа. Онгон байгалиас эмийн ургамлыг сорчлон иддэг монгол малын махаа дэлхийн хэрэглээ болгох эдийн засгийн үр ашиг ч харагдаж л байна. Мөн дорнын төдийгүй монголын уламжлалт анагаах ухааны нууц, эмчилгээний арга барилыг дэлхий нийт илт сонирхож байгаа талаар шинжлэх ухааны байгууллагуудын мэдээлэл хангалттай харуулж байна. Энэ өнөөх л гайт COVID-19-ийн монгол үндэстэнд зориулсан “хаялга”.

**МОНГОЛЫН УЛАМЖЛАЛТ АНАГААХ УХААНЫ НУУЦ, ЭМЧИЛГЭЭНИЙ АРГА БАРИЛЫГ ДЭЛХИЙ НИЙТ ИЛТ СОНИРХОЖ БАЙГАА НЬ ӨНӨӨХ Л ГАЙТ COVID-19-ИЙН МОНГОЛ ҮНДЭСТЭНД ЗОРИУЛСАН “ХАЯЛГА”.**

**Коронавирус манай гадаад харилцааны түүхэнд сайнаар дурсагдах үйл явдлыг ч авчирсан гэдэгтэй маргахгүй биз. Өвчинд нэрвэгдсэн хятадуудаас бүгд дөлж байхад манайх өвөрмөц тактик хэрэглэж дипломат харилцаагаа нэг шатаар ахиулсан нь яах аргагүй үнэн юм. “Алтан аргамж” болсон өмнөд хөрштэй өнө мөнх зэрэгцэн оршихоос хойш мууг сайнаар эргүүлэх боломжийг ашигласан нь монголчуудын мэргэн ухаан билээ л.**

Мууг сайнаар эргүүлэх нь овжин үйлдэл болохын хувьд бид хүнд байдлаас сайныг олох нь “суусан газраасаа шороо атгасан” лугаа тул нийгмээ цэвэрлэж авах ашиг тустай хэрэг. Цаашдаа ч карантин муухайг сайхнаар өөрчлөх олон боломжийг олгох вий. “Юм яаж ч муудсан сайжрах талруугаа явж байдаг” гэх өөдрөг үзлээр боломж бүхнийг ашигтайгаар эргүүлэх нь чухал. Мөн сайжруулсан ололтоо муутайгаа эргэн хутгахгүйн төлөө ололт, дадал бүрээ өнгөлөн зүлгэж, омогшлоо эмгэгшүүлэхгүй байх даалгаврыг амжилттай биелүүлэх нь хамгаас чухал юм. ■

### [ЗГМ СОНИН]

“Засгийн газрын мэдээ” сонин нь ардчилсан, шуударга ёс, хүний эрхийг дээдэлж, чөлөөт сэтгүүл зүйн хэм хэмжээг бүрнээ сахин, олон ургальч үзлийг илэрхийлэх мэдээллийн индэр байж, нийт Монгол үндэстний ойлголцол, эв нэгдлийг бэхжүүлэхийг эрхэм зорилгоо болгоно.

ТУЗ-ийн дарга  
**Эрдэнэбаатарын ДОЛГИОН**  
Ерөнхий эрхлэгч  
**Баатарын Дуламхорлоо**  
Зөвлөх  
**Шатарбалын Даваадорж**  
Орлогч эрхлэгч  
**Лхагважавын Сугармаа**  
Утас: 99903584

#### РЕДАКЦ

Улс төр, нийгэм, эрэн сурвалжлах мэдээллийн алба  
Эдитор Б.Энхжаргал  
Утас: 99901621  
Эдийн засаг, уул уурхайн мэдээллийн алба  
Эдитор Б.Баяртогтох  
Утас: 99901532  
Цахим контент, бүтээлч үйлдвэрлэлийн алба  
Эдитор Г.Баярсайхан  
Утас: 99903574

#### ЗАР СУРТАЛЧИЛГАА

Утас: 99903581  
99903578  
99907843

#### ЦАХИМ ХУВИЛБАР

zgm.mn  
ubinfo.mn

#### ХАЯГ

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
I хороо, Энхтайваны өргөн чөлөө,  
“Блю Скай тауэр” 407 тоот  
Улсын бүртгэлийн дугаар. 1024  
Утас: 70103131,  
Факс: 70106065

#### ДУГААРЫН УДИРДАГЧ

**Л.Сугармаа**  
**ТОДРУУЛГА & ЗАЛРУУЛГА**  
Уншигч та манай сонины мэдээ, нийтлэл, сурвалжилгатай холбоотой тодруулж, залруулах шаардлагатай санал, хүсэлт байвал  
· INFO@ZASAG.CO  
Утас: 99903584 хаягаар бидэнтэй холбогдоно уу.

# НИЙТЛЭЛЧИЙН БУЛАН



Дэлхийн улс орнууд хүнд байдалд ороод байгаа авиа компаниудаа аварч үлдэхийн тулд төрөл бүрийн арга хэмжээ авч эхэллээ

📷 Гэрэл зургийг С.Батсайхан

## ЧӨДРИЙН ГАНЦАА АВРАХ УУ, АЛДАХ УУ ГЭДГЭЭ ЭЗЭН НЬ МЭДЭЖ ДЭЭ

✍ Ш. Алтай, ЗГМ сонин

**М**онголын төрийн өмчит МИАТ компани цаашид оршин байх эсэх дээрээ тулчихаад байна. Өөрөөр хэлбэл, коронавирусийн хорио цээрээс болж үндэсний брэнд болсон агаарын тээврийн ганц компани маань дампуурлаа зарлахад хүрээд байна гэсэн үг. Энэ нь тус компанийн удирдлага, менежментийн бодлогын алдаанаас болж ийм асуудалтай нүүр тулж байгаа хэрэг биш юм. Өнөөдөр ганц Монголын МИАТ компани биш дэлхийн бүх улс орнуудын агаарын тээврийн компаниудад ийм аюул тулгараад байгаа билээ. Мэдээж шалтгаан нь шинэ төрлийн коронавирусийн цар тахал. Тиймээс, хэдийгээр төрийн өмчит нэртэй боловч, улсын төсвөөс нэг төгрөгийн ч татаас авдаггүй, харин төсөвт мэдэгдэхүйц хувь нэмэр оруулдаг болсон ганц авиа компани амьдруулах уу, амыг нь барих уу гэдгээ эзнийхээ хувьд Монголын Засгийн газар шийдэх хэрэгтэй болжээ. Эдүгээ “Эрдэнэт” үйлдвэр, III, IV ДЦС, “Эрдэнэс -Тавантолгой” гэх мэт төрийн өмчит цөөхөн компани бий. Гэхдээ МИАТ компанийн тухайд зөвхөн зорчигчдын урсгалаас санхүүждэг, эндээс олсон ашиг орлого дээрээ оршин тогтнодог онцлогтойгоороо бусдаасаа ялгаатай гэж хэлж болно. Улсаас татаас авдаггүй болохыг нь дээр дурдсан. Нэгэн үед энэхүү компанийн үйл ажиллагаа доголдож, улмаар алдагдалд орж, дампуурах шахаж байсан түүх бий. Гэвч 2015 оноос хойш ашигтай ажилладаг болж, улсын нэгдсэн төсөвт 75.3 тэрбум

төгрөг оруулдаг үнэ цэнтэй аж ахуйн нэгжийн нэг болсон юм. Зөвхөн өнгөрсөн 2019 онд гэхэд л 35.3 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан үндэсний ганц авиа компани маань эдүгээ үйл ажиллагаагаа зогсоохдоо тулсан нь тун харамсалтай. Үнэндээ чөдрийн ганц ч морьгүй хүн лүгээ болчихвол улс орон минь нэг л өрөвдөлтэйгээ санагдаад байна. Дэлхийн улс орнууд хүнд байдалд ороод байгаа авиа компаниудаа аварч үлдэхийн тулд төрөл бүрийн арга хэмжээ авч эхэллээ. АНУ гэхэд л 40 тэрбум ам.долларыг авиа компаниуддаа зориуллаа.

**ДЭЛХИЙН УЛС ОРНУУД ХҮНД БАЙДАЛД ОРООД БАЙГАА АВИА КОМПАНИУДАА АВАРЧ ҮЛДЭХИЙН ТУЛД ТӨРӨЛ БҮРИЙН АРГА ХЭМЖЭЭ АВЧ ЭХЭЛЛЭЭ. АНУ ГЭХЭД Л 40 ТЭРБУМ АМ.ДОЛЛАРЫГ АВИА КОМПАНИУДДАА ЗОРИУЛЛАА.**

Олон улсын Агаарын тээвэр-лэгчдийн холбооноос (IATA) дэлхийн улс орнуудын Засгийн газарт хандаж, агаарын тээврийн компаниуддаа боломжоороо тусалж, дэмжихийг уриалсан. Энэ уриалга нь Монголын Засгийн газарт ч хамаатай юм. Тус холбооны таамаглаж байгаагаар олон улсын агаарын тээврийн компаниуд энэ онд 252 тэрбум ам.долларын боломжит орлогоо алдах болоод буй юм. Эгнээндээ 290 компанийг нэгтгэсэн IATA-

гаас уриалга гаргасны дараа Засгийн газрууд эдийн засаг, бизнесүүдээ дэмжих далайцтай арга хэмжээндээ агаарын тээврийн салбараа хамруулан, анхаарч эхлэхдээ ийм хямралтай хэзээ ч тулгарч байгаагүйгээ онцолжээ. МИАТ компанийн хувьд байдал тун хүнд болоод байгааг Засгийн газар маань анхаарахгүй бол хожимдож мэдэхээр байна. Одоо бол айж, эмээж нэр хичээх бус зоригтой, шийдэмгий арга хэмжээ л энэ салбарыг аврах болно гэдгийг мэргэжилтнүүд нь онцолж байгааг ЗТЯ-ны сайдад дуулгачихмаар байна. Ядаж энэ асуудлаа Засгийн газартаа оруулахад нь шпаргалк болог л дээ. Салбартаа анхаарах нь сайдын үүрэг шүү дээ. МИАТ компанийнхан болохоор Засгийн газрын дэмжлэг энэ тэр гэсэн гоё үгэнд итгэл муутай байна. Яг цаг дээрээ тулахаар худлаа болж амлалтаасаа буцах тохиолдол манай Засгийн газарт гэм биш зан болоод тогтчихсон нь төрийн өмчит компаниудыг хашраадаг бололтой. Дэмжлэг нь бодит боллоо гэхэд хэрэгжилт нь удаж залхаана. Яг үнэндээ төрийн өмчит компаниудийг саамших үед нь саймширч, хамаг саалийг нь авчихаад, сааль татрахад гаргуунд нь гаргачихдаг эзэнтэй байж болохгүйн тухай л өгүүлж буй санаа минь юм. МИАТ-ийн тухайд одоо олон улсын бүх нислэгээ зогсоож даруй сар илүү болох гэж байна. Энэ он гарсаар эхний улиралд 90 тэрбум төгрөгийн орлого олох байсан бол эдүгээ 52 тэрбум төгрөгөө шууд алдчихаад байна. Энэ алдагдал дөрөвдүгээр сарын эцэс гэхэд 97 тэрбум төгрөгт хүрэх гэнэ. Хэдийгээр тус компани ажилтнуудынхаа цалингийн 60 хувийг нь олгож, дотооддоо бүх зардлаа хэмнэж, тэвчиж болох

бүх төслийн санхүүжилтийг зогсоосон ч, яах аргагүй л тамир тэнхээ шавхагдаж байгаагаа Засгийн газарт дуулгахаар болж байгаа юм байна. Тэдний хүсээд байгаа дэмжлэг нь 40-50 тэрбум төгрөгийн зээл юм билээ. Цар тахлын аюул холдож, агаарын тээвэр сэргэвэл МИАТ компани эл зээлээ үйл ажиллагаагаараа тун ч хөнгөхөн төлж дөнгөнө. 2013 онд Засгийн газрын баталгаагаа гаргаж зээлээр авсан Boeing 764 ER онгоцны үнэ болох 147 сая ам. долларыг МИАТ компани төлчихөөд байгаа билээ. Одоо 2023 онд төлж дуусгах 47 сая ам.долларын үлдэгдэл бий. Төрийн өмчит компанийн асар том зовлонгийн нэг нь үр ашигтай бол өмчлөх эзэн олддоод, өвдөг сөхрөх болоод ирэхэд тулж туслах эзэнгүй хаягдчих гээд байдаг явдал байдаг. Хувийн аж ахуй биш болохоор төрийн өмчит компани нь шийдвэр гаргах эрх бүхий аль ч этгээдүүдийн өмч биш. Тиймээс компани ийм нөхцөлд үнсэнд хаягдсан шалз мэт болдог байна. МИАТ компани дампуурлаа гэхэд бид гаднын аль нэг авиа компанийг оруулж ирэхээс аргагүй болно. Өөрийн биш хүний нохойг монголчууд хооллож, тэжээх болно гэсэн үг. Аль нь бидэнд ашигтай болохыг Засгийн газар маань шийдэх л хэрэгтэй болж байна. Хэдийгээр Засгийн газрын шийдвэрээр “тэг” зогсолт хийж, долоо хоногт олон улсын 32 нислэг үйлддэг (өвлийн улиралд хийдэг нислэгийн тоо) байсан бол хөл хорионы дэглэм тогтоосноос хойш МИАТ зөвхөн иргэдээ авчрах зорилгоор БНСУ-руу хоёр удаа,

Япон руу 1 удаа, Турк, Бээжин рүү тус бүр нэг удаа л нислэг хийлээ. Үйл ажиллагаандаа ямар нэгэн дэмжлэг буюу хүссэн зээлээ авч чадахгүй бол хоёр сарын дараа дампуурлаа зарлахаас аргагүйд хүрэх нь. Удах тусам байдал хүндэрч байна. Энэ байдлаар МИАТ энэ олон жилийн үйл ажиллагаагаараа олж авсан олон улсын чиглэлийн нислэгийн алтан эрхээ алдахад хүрнэ. Тухайлбал Сөүл, Бээжин, Токиогийн алтан эрхээ гаднынханд алдана. Дахиад МИАТ сэргэлээ гэж бодоход ийм эрхтэй болтлоо олон жилийг зарцуулах болно. Нэгэнт бий болсон, хөл дээрээ тэнцчихсэн үр ашигтай аж ахуй нэгжээ тордож додомдоод хүнд цагийг туулчихвал Монгол Улсад л хэрэгтэй

баймаар. Монголбанк, Хөгжлийн банк яг ямар үүрэгтэйг энэ үед монголчууд мэдэхээ байлаа. Тэдний нэг гол үүрэг нь чухам л МИАТ мэт аж ахуй нэгжүүдэд бодлогоор туслах явдал мөн биз дээ. Эс бөгөөс ямар юмных нь Хөгжлийн банк байх билээ. Нарьгүй дээрээ энэ асуудал Засгийн газрын оролцоогүйгээр Монголбанк чухам ийм үед л МИАТ мэтийн авсан зээлээ төлөх чадвартай компаниудад тусалж, арилжааны банкны заавал байлгах нөөцийг зээлийн хэмжээгээр нь бууруулах гэх мэт уян хатан бодлого хэрэгжүүлж яагаад болохгүй гэж. Энэ чинь хөгжлийн бодлого болно шүү дээ. МИАТ-д одоо л тусламж хэрэгтэй, эс бөгөөс төрийн алтан соёмбот далбаатай мөнгөн хөлөг агаарт дүүлэхийг дахин хэзээ ч бид харахгүй болно. ■

## ЗГМ: ТОВЧХОН

## ■ ТАТВАР

Таны автомашины улсын дугаар 4 болон 9 тоогоор төгссөн бол энэ сард багтаан татвар төлөх ёстой. Авто тээврийн хэрэгсэл эзэмшигчид ухаалаг утасны smartcar аппликейшн болон тээврийн хэрэгслийн нэгдсэн цахим үйлчилгээний www.smartcar.mn, www.itax.mta.mn цахим хуудсанд хандан тээврийн хэрэгслийн татвар, агаарын бохирдол, зам ашигласны төлбөрийг онлайн төлбөрийн карт, QR-код төлбөр хийх боломжтой аж.

## ■ ХАНДИВ

Монгол Улсад шинэ төрлийн коронавирустай тэмцэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор Bank of China эмнэлгийн хамгааллын хувцас хэрэгсэл хандивлахаар болсон талаар тус банкны Улаанбаатар дахь төлөөлөгчийн газраас мэдээллээ. Хандивт эмнэлгийн зориулалттай амны хаалт, бээлий, хамгаалалтын хувцас, нүдний шил зэрэг нэн чухал шаардлагатай зүйл багтсан байна. Дээр дурдсан хандивын бүтээгдэхүүнийг тус банкны Шанхай салбараас бэлтгэж дууссан ба Монгол Улс руу тээвэрлэлт хийхээр эзхэж байгаа ажээ.

## ■ НИТХ

НИТХ-ын тэргүүлэгчдийн ээлжит хуралдаанаар нийслэлийн 38 байршлын 130 га газрыг нийтийн эдэлбэр газраар тогтоолоо. Тодруулбал, Баянголын хоёр байршилд 0.49 га, Баянзүрх дүүргийн 10 байршилд 26.69 га, Сонгинохайрханд 4.83 га, Сүхбаатар дүүрэгт 3.6 га, Хан-Уулд 2.65 га, Чингэлтэйд 92.2 га газрыг нийтийн эзэмшилд шилжүүлжээ.

## ■ БОЛОВСРОЛ

Боловсролын үнэлгээний төвөөс элсэлтийн ерөнхий шалгалтад бэлтгэгчдэд зориулан “Цахим зөвлөх” www.help.eec.mn портал сайт ажиллуулж эхэллээ. Дээрх сайтаас теле хичээл, зөвлөмж, жишиг даалгавар, ЭЕШ-ын журам болон ЭЕШ тай холбоотой бүхий л төрлийн зөвлөгөө мэдээллийг нэг дороос авч болох гэнэ. Мөн тус сайтад хандан сонирхсон асуултаа хариулт авах боломж бүрдүүлжээ.

## ■ ТҮҮХИЙ ЭД

Түүхий эдийн “Эмээлт” захад хонины нэхий ширхэг нь 1000, өлөн 1000 төгрөгийн үнэтэй байна. Үүнээс гадна ямааны арьс ширхэг нь 20 мянга, борлонгийн арьс 5000-6000, ноолуур кг нь 75-80 мянган төгрөгийн ханштай байгаа аж. Тэгвэл адууны шир сүүлтэй нь 10 мянга, адууны сүүл ширхэг 8000, кг нь 13 мянга, дэл кг нь 4000, цагаан адууны шир ширхэг нь 40 мянган төгрөгийн үнэтэй байв.

## АН АГНУУР

БОАЖЯ-наас ирэх зургадугаар сарын 15 хүртэл загас агнахгүй байхыг БОАЖЯ-наас анхаарууллаа. Энэ нь өчигдрөөс хэрэгжиж байгаа бөгөөд үржлийнх нь үед агнавал тухайн төрөл зүйл устах аюултай. Үүнийг зөрчвөл хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний мөнгөн дүнгээр торгоно.



Гэрэл зургийг Ж.Гэрэлчулуун

## Туркийн хоёр иргэнээс коронавирус илэрлээ

Коронавирус илэрсэн хоёр хүний нэг нь Элчин сайдын гэргий байжээ

Б.Мөнхзул, ЗГМ сонин

Эрүүл мэндийн яамны мэдээллээр Коронавирусийн халдвар 205 оронд бүртгэгдсэн бөгөөд Африкийн орнуудад өвчлөл эрчимтэй тархах эрсдэл байна. НҮБ-ын гишүүн орнуудаас 19 оронд халдвар илрээгүй. Манай улсын хувьд одоогоор нийт

2272 хүн ажиглалтад буй бөгөөд биеийн байдал нь хэвийн” гэв.

Тэгвэл ХӨСҮТ-ийн захирал Д.Нямхүүгийн өгсөн мэдээллээр тусгаарлалтад байсан Туркийн хоёр иргэнээс корона вирус илэрчээ. Тэдний нэг нь Туркийн Элчин сайдын гэргий байсныг онцолсон юм. **Дээрх хүмүүс энэ сарын 28-нд манай улсад газардсан Солонгосын тусгай үүргийн онгоцоор ирсэн**

ажээ. Тэднийг онгоцноос буусан даруйд нь тусгаарласан учраас бүгдийг хяналтад авчээ. Мөн Токио-УБ онгоцоор ирж, тусгаарлалтад байсан 25 хүний шинжилгээний хариу сөрөг гарчээ. Улсын хэмжээнд уушгины хатгалгаагаар өвчилсөн хүмүүсээс түүврээр сорьц авч, шинжлэхэд корона вирус илрээгүй байна. Хоёр хоногийн өмнө корона вирусээр халд-

варласан хоёр иргэн бүрэн эдгэрч, эмнэлгээс гарсан ч дахин хүн нэмэгдлээ. Ингэснээр Монгол Улсад Covid-19 вирусийн 14 тохиолдол бүртгэгдлээ.

**БНСУ-д  
КАРАНТИНЫ  
ДЭГЛЭМ  
ЗӨРЧВӨЛ ЭНЭ  
САРЫН 5-НААС  
ТОРГУУЛИЙН  
ХЭМЖЭЭГ 10 САЯ  
ВОН БОЛГОЖ  
ӨСГӨХ, ЭСВЭЛ НЭГ  
ЖИЛ ХҮРТЭЛХ  
ХОРИХ ЯЛААР  
ШИЙТГЭХЭЭР  
ӨӨРЧИЛЖЭЭ.**

### КОРОНАВИРУС ДЭЛХИЙД

Өчигдийн 11:00 цагийн байдлаар 755 мянган хүн COVID-19-ийн халдвар авч, 36500 хүн нас баржээ. Тус өвчин анх мэдээлэгдсэнээс хойш 100 хоног өнгөрч байгаа аж. Хамгийн өндөр дэгдэлттэй байгаа Европ тивд өдөрт 30 мянгаас дээш тохиолдол бүртгэгдэж байна.

Их Британид хийсэн судалгаагаар Европын 11 улсад хөл хорио тогтоосноор 59 мянган хүн амь насаа алдахаас сэргийлж чадсан гэж дүгнэжээ. Тэгвэл БНСУ-д карантины дэглэм зөрчвөл гурван сая хүртэл воны торгууль ногдуулах бол энэ сарын 5-наас торгуулийн хэмжээг 10 сая болгож өсгөх, эсвэл нэг жил хүртэлх хорих ялаар шийтгэх өөрчлөлт оруулсан байна. ■

## ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2020.04.02

**ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН НЭР:** Сантехникийн хаалт, хоолой, шланг, холхивч, сальник нийлүүлэгчийг сонгон шалгаруулах /багцтай/.  
**ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ДУГААР/ГЭРЭЭНИЙ ДУГААР:** УСУГ-БМ-2020-09  
Ус сувгийн удирдах газар эрх бүхий тендэрт оролцогчдоос сантехникийн хаалт, хоолой, шланг, холхивч, сальник нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тухай цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Тухайн тендэрт эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр **50,000 /тавин мянган/** төгрөгний цахим тендерийн хураамж төлж оролцоно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **30 хоногийн** дотор хүчинтэй байна.

Тендэрт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

**Сүүлийн 2 жил буюу 2018, 2019 онуудын Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлнэ.**

**Сүүлийн 2 жилд буюу 2018, 2019 он тус бүрт ижил төстэй гэрээ хийсэн тухай мэдээлэл ирүүлнэ.**

**Борлуулалтын орлого нь сүүлийн 2 жил /2018, 2019/ тус бүр тухайн багц тус бүрийн төсөвт өртгийн 100 хувиас дээш байх.**

**Нэг оролцогч тухайн тендерийн 2 хүртэлх багцад санал ирүүлж болно. Хэрэв 3 дахь багцад санал ирүүлсэн тохиолдолд түүнийг үнэлэхгүй болохыг анхаарна уу.**

**Тендерийн хамт**

**Багц-1** 1,447,000 /нэг сая дөрвөн зуун дөчин долоон мянган/ төгрөг,

**Багц-2** 1,343,000 /нэг сая гурван зуун дөчин гурван мянган/ төгрөг,

**Багц-3** 276,000 /хоёр зуун далан зургаан/ төгрөг,

**Багц-5** 522,000 /таван зуун хорин хоёр мянган/ /төгрөгний тендерийн баталгаа тус тус ирүүлнэ.

Хүчинтэй байх хугацаа: **2020 оны 07 дугаар сарын 01-ны өдрийг дуустал.**

Тендерийг **2020 оны 5 дугаар сарын 04-ны өдрийн 10 цаг 00 минутаас өмнө** цахим системээр тендерийн материалаа ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендэрт оролцогчдыг байлцуулан тендерийг **2020 оны 5 дугаар сарын 04-ны өдрийн 10 цаг 30 минут-аас** нээно.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Багц-3 дээр** дотоодын давуу эрх тооцно.

**Бусад багц дээр** дотоодын давуу эрх тооцохгүй.

Гадаадын этгээд **оролцох эрхгүй.**

**Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Ус Сувгийн Удирдах газар, Токиогийн гудамж-5, өөрийн байр, С.Чинбаатар Утас: 70157018-121**

## “Буянт-Ухаа 2” хорооллын есөн орон сууцыг гачигдалтай иргэдэд олгоно

“Нийслэлийн орон сууцны корпорац”-аас 2019 онд “Буянт-Ухаа 2” орон сууцны хорооллын 972 айлын орон сууцыг зорилтод бүлгийн

найман ангилалд хуваарилж, түрээсийн болон түрээслээд өмчлөх хэлбэрээр орон сууцжуулах ажлыг зохион байгуулсан. Энэ ажлын хүрээнд гамшигт үзэгдлийн улмаас орон гэргүй болсон иргэдэд 15 орон сууц хуваарилсан юм. Холбогдох журмын дагуу зургаан иргэн орон сууцандаа орсон бөгөөд өдгөө есөн байр сул үлджээ.

Холбогдох журмын дагуу зургаан иргэн орон сууцандаа орсон бөгөөд өдгөө есөн байр сул үлджээ. Тиймээс тус байруудыг үр

ашигтай байлгах, зорилтот бүлгийн иргэдийг орон сууцаар хангах хүрээнд гачигдалтай иргэдэд олгох асуудлыг НИТХ-ын Тэргүү-

лэгчдийн хуралдаанаар шийдвэрлэлээ. Ингэснээр дээрх есөн байрыг Орон сууцны тухай хуулийн дагуу дээрх зорилтот бүлгийн хүмүүст олгох юм. Дашрамд дурдахад, “Нийслэлийн орон сууцны корпорац”-аас орон сууц

баруулсан тохиолдолд таван хувийг нь гамшигийн улмаас орон гэргүй болсон иргэдэд хуваарилах квотыг НИТХ тогтоож өгсөн байдаг аж. ■

Т.Намуун, ЗГМ сонин

### САЛХИНЫ ХАГАЛБАРТ ОРШДОГ УЛААНБААТАРЫН ИРГЭДЭД ДҮҮЖИН ТЭЭВЭР ХАМГИЙН ЭРСДЭЛТЭЙ

Нийслэлийн захиргаанаас авто замын түгжрэлийг бууруулах, нийтийн тээврийг хөгжүүлэх цогц төсөл олон нийтэд танилцуулж, 2021 оноос агаарын дүүжин тээврийг нэвтрүүлнэ гэж мэдэгдсэн. Тус унаа нь 157 кабинаар нэг цагт 3000, жилд 3,2 сая хүртэлх зорчигч тээвэрлэх аж. Чихэн дээр нь цэцэг ургуулна гэдгийн адил тооцоо судалгаа хийсэн гэх уг төсөл манай хотын газар зүйн байрлал, цаг уурын онцлогоос эхлээд эдийн засгийн чадамж, аюулгүй байдалд ч нөлөөлөх эрсдэлтэйг мэргэжилтнүүд анхааруулж буй. Тус төслийн талаар -50, +50 хэмд ашиглах боломжтой, хамгийн аюулгүй тээврийн хэрэгсэл хэмээсэн нь анхаарал татахгүй байхын аргагүй. Учир нь Улаанбаатар хот 1350 метрийн өндөрт байрладаг бөгөөд баруун хойд зүгээсээ тогтмол салхилдаг. Жилийн 260 гаруй өдөр нь салхилдаг учраас дүүжин тээвэр савлах, салах, хурдан хугацаанд элэгдэх наад захын эрсдэлтэй. Энэ төслийг дэлхийн олон орон амжилттай нэвтрүүлсэн гэх боловч тэдгээр оронд агаарын тээвэртэй холбоотой аймшигт ослоуд хэд хэд гарч байв. Тухайлбал, 2017 онд буюу ердөө хоёрхон жилийн өмнө Энэтхэг улсын Гулмарг, Жамму, Кашмир мужуудад хүчтэй салхины улмаас хэд хэдэн кабин модонд цохигдож, унасан бөгөөд долоон хүн амиа алдаж байв. Мөн 1983 оны нэгдүгээр сарын 29-нд Сингапурт хоёр кабелийн машин 55 метр гүн далайд унаж, мөн



© НҮҮГИЙН ГЭРЛЭГ

# Салхи ихтэй Улаанбаатарт дүүжин тээвэр тохиромжгүй

Улаанбаатарт жилийн 260 гаруй өдөр салхилдаг учир дүүжин тээвэр савлах, салах, хурдан хугацаанд элэгдэх эрсдэлтэй

долоон хүний амь эрсэдсэн юм.

### АГААРЫН ТЭЭВРИЙН НЭГ КМ ЗАМЫГ \$10-40 САЯАР БАРЬДАГ

Агаарын тээврийг дэлхийд Англи, Хонконг, Сингапур, АНУ, Швейцар зэрэг орнууд ашигладаг. Гэвч тус тээврийн нэг км замын өртөг 10-40 сая ам.доллароор байдаг аж. Эндээс харахад дүүжин тээврийг ашигласнаар дэд бүтцийн зардал маш их гарах

**ЗАМЫН ТҮГЖРЭЛИЙГ  
20-30 ХУВЬ БУУРУУЛАХ  
ТООЦОО ХЭДИЙН  
ГАРСАН BRT ТӨСӨЛ  
2012 ОНД БАТЛАГДАЖ  
БАЙВ. BRT НЬ АВТО  
ЗАМЫН 2-4 ДЭХ ЭГНЭЭГ  
ТУСГААРЛАХ БӨГӨӨД,  
ТУС ЗАМААР ЗӨВХӨН  
НИЙТИЙН ТЭЭВРИЙН  
ХЭРЭГСЭЛ ЗОРЧИХ ЮМ.**

нь тодорхой. Мэргэжилтнүүдийн хэлж буйгаар томоохон байгууламж, гүүрэн замуудад 100 жил, орон сууцанд 40 жил гэх мэт баталгаа өгдөг бол дүүжин тээвэр нь буюу кабелиас тогтдог учраас гурван жилийн баталгаа авах ч боломжгүй байдаг аж. Улмаар байнгын хөдөлгөөнт элемент нар салхи, даац болон хэрэглээний элэгдэлд орж, маш их хэмжээний ашиглалтын зардал шаарддаг байна.

### ЗГМ: ТОДРУУЛГА

## Л.Ану-Үжин: Нийтийн тээврийн менежментээ сайжруулж, тусгай замын автобусыг нэвтрүүлэх нь үр дүнтэй шийдэл

Энэ асуудлын талаар Хотын засаглалын мэргэжилтэн Л.Ану-Үжингээс тодруулга авлаа.

**-2021 оноос ашиглалтад орох агаарын тээврийг Баянхошуу-Ханын материал-3,4-р хорооллын эцэс болон Долоон буудал-Дарь эх- Сансар гэсэн хоёр чиглэлд явуулахаар төлөвлөж байгаа. Газар зүйн байршил, хот төлөвлөлт талаасаа энэ оновчтой шийдэл болж чадсан уу?**

-Дүүжин тээврийг өндөрлөг газрын хооронд буюу энгийнээр хэлбэл хэц татдаг системээр барьдаг. Гэтэл сонгож авсан энэ чиглэл нь нэг уулын гурван талд байрладаг, гэр хороолол ихтэй хэсэг. Энэ бүс хурдан хугацаанд хөгжиж, ойрын хугацаанд орон сууцанд шилжих боломжтой. Хэрвээ энэ бүсэд өндөр барилга баригдаж, бүтээн байгуулалт хийвэл хоорондоо зохицох

боломжгүй болно. Мөн зам тээврийн төлөвлөлтийг хийхдээ тухайн тээврийн хэрэгслийг өөр ямар бүтэцтэй хослуулан хэрэглэх боломжтой вэ гэдгийг заавал тооцоолох ёстой. Өөрөөр хэлбэл, та галт тэрэгнээс буугаад ямар унаагаар гэртээ харих вэ гэдэгт хариулт өгөх шаардлагатай байдаг. Гэтэл кабель зам нийтийн тээврийн бусад хэрэгсэлтэй нэгдсэн систем үүсгэх ямар ч боломжгүй. Бүх хүний зорчих маршрут Баянхошуунаас хорооллын хооронд биш шүү дээ. Мөн иргэний эзэмшиж буй газрын агаарын орон зай нь тухайн хүний өмч байдаг. Хэрвээ агаарын тээвэр зорчвол өмчлөгч этгээд энэ газрыг хөгжүүлэх, нэмж барилга байгууламж барих, борлуулах боломжгүй болж байгаа юм.

**-Хотын дарга агаарын тээврийн аюулгүй байдлыг**

**бүрэн хангаж чадна гэж үзэж буйгаа илэрхийлсэн. Манай улс төв Азийн хамгийн өндөрлөг хэсэгт байрладаг, салхины хагалбар бүс. Үүнээс үүдэх эрсдэл бий юу?**

-Агаарын дүүжин тээвэрт хамгийн чухал зүйл бол аюулгүйн шаардлага. -50, +50 градуст хэвийн ажилладаг, аюулгүй тээврийн хэрэгсэл гэж танилцуулж байгаа ч манай улсад агаарын хэмээс илүү салхины хүчийг тооцоолох нь чухал. Улаанбаатар баруун хойноосоо буюу Толгойт, Зүүн салаа хэсгээс хамгийн хүчтэй салхилдаг. Чингэлтэй уул, Сонгинохайрхан уулын завсраар орж ирдэг энэ их салхины хүч ямар нэгэн биетээс зүүгдээд явж буй тээврийн хэрэгсэлд эрсдэл үүсгэнэ гэсэн үг.

**-Дэлхийн олон оронд энэ тээврийг ашигладаг. Манай улс**

**аль улсын туршлагаас судалвал оновчтой вэ?**

-Яг манайд нэвтрүүлэх гэж буй дүүжин тээврийн энэ загварыг аль ч улсын нийтийн тээвэрт ашигладаггүй. Саяхан Дубай хот ашиглах шийдвэр гаргасан. Дубайн газар зүйн байрлал нь манайх шиг өндөрлөг бүс. Тэр чигээрээ тал буюу хавтгай газар нутагтай. Далайн эрэгт байрладаг учраас цаг уурын өөрчлөлтөөс шалтгаалж усанд автах бэрхшээл болон элс тоосны асуудалтай тулгардаг. Мөн маш их мөнгөтэй, шинэ зүйлсийг туршиж, түүгээрээ маркетинг хийж, аялал жуулчлалаа хөгжүүлдэг хот. Тиймээс туршиж үзэхэд Дубайд ямар нэг алдагдал байхгүй. Гэхдээ олон улсын шинжээчид энэ шийдвэрийг шүүмжилсээр байгаа. Энэ хот нийтийн тээврийн байж болох бүх хувилбарыг ашиглаж байна. Шинийг туршиж

байгаа нь манайх шиг улсад суралцах боломж болж өнгө.

Гэтэл автобусаа ч бүрэн ашиглаж чаддаггүй манай улсын хувьд нийтийн тээвэртээ маш олон шинэчлэл нэвтрүүлэх боломжтой.

### -Тухайлбал?

-Жишээ нь, BRT системийг нэвтрүүлж болно. Энэ нь автобус зөвхөн тусгай замаар зорчино гэсэн үг. Манайх автобусны менежментээ л бүрэн хийж чадаагүй. Хамгийн наад зах нь хотын төвийн дүүргүүдэд автобус очдоггүй, автобус ашиглахад хүндрэлтэй газрууд маш олон байна. Эхний ээлжинд автобусны чиглэл, тоо хэмжээг нэмэх, хөрөнгө оруулалтыг нь сайжруулж, холын замын автобус, ойрын зайны автобус гэх мэтээр менежментийн зохицуулалт хийж, одоогийн дэд бүтэцдээ ашиглах боломжтой нийтийн тээврийг нэвтрүүлэх хэрэгтэй. ■

## ЭДИЙН ЗАСАГ

⊖ Ноолуурын үнийг яам биш зах зээл тодорхойлно

➔ 9

⊖ Хямралын эсрэг арга хэмжээ авах нь зөвч ирэх жилүүдэд анхаарсан эдийн засгийн бодлого чухал

➔ 10

⊖ Азийн цагаан будааны экспортод хүндрэл учирч эхэллээ

➔ 11

⊖ Коронавирус тархаж буйг эрт тодорхойлох шинэ арга нээжээ

➔ 11

## ЗГМ: ТОВЧХОН

## ■ АРИЛЖАА

Монголын хөрөнгийн бирж лхагва гарагийн үнэт цаасны арилжаагаар 26 компанийн 189,023 ширхэг хувьцаа арилжлаа. Энэ өдөр 13 компанийн хувьцааны ханш өсөж, 10 компанийнх буурлаа.

## ■ ИНДЕКС

0.13

Хувь. ТОП 20 индекс 0.13 хувиар өсөж, зах зээлийн үнэлгээ 2.48 их наяд төгрөг боллоо. Хөрөнгийн зах зээлийн тэргүүлэх индекс 12 өдрийн дараа эргэн өсөлт үзүүлээ. Гэвч зах зээлийн үнэлгээ 2.6 их наядаас 2.48 их наяд болж буурлаа.

## ■ УУЛ УУРХАЙ

82.8

Сая ам.доллар. Оны эхний хоёр сарын байдлаар экспорт буурч, шууд хөрөнгө оруулалт багассанаар төлбөрийн тэнцэл 82.8 сая ам.долларын алдагдалтай гарлаа.

## ■ ТӨСӨЛ

35

Хувь. Xanadu Mines компани Өмнөговь аймгийн нутагт орших Хармагтай ордын алмаазан өрөмдлөгийн ажил хоёрдугаар сард зогсож, талбай дээр ажиллаж байсан багийнхан нь гэр рүүгээ явсан байна. Улмаар 2020 оны удирдлагын зардлаа 2019 оныхтой харьцуулахад 1.3 сая австрали доллар буюу 35 хувиар танахаар зорьж байна.

## ■ ХУДАЛДАА

1.1

Тэрбум ам.доллар. Монгол Улс энэ оны эхний улиралд нийт 1.1 тэрбум ам.долларын экспорт хийжээ. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 34.4 хувийн бууралттай байна. Харин 1.2 тэрбум ам.долларын импорт хийжээ.

## ■ АЛТ ТУШААЛТ

Төв банкны худалдаж авсан үнэт металлын хэмжээ оны эхний гурван сард 5.3 тонн хүрчээ. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад дөрөв дахин өссөн үзүүлэлт энэ боллоо. Үнэт металлын 3.6 тонн нь алт, 1.7 тонн нь цагаан мөнгө байна.



⊖ 2020 онд “Эрдэнэс Тавантолгой” хэдий хэмжээний ашигтай, алдагдалтай ажиллах эсэх нь тодорхой бус байна.

Гэрэл зургийг С.Батсайхан

# ЗАСГИЙН ГАЗАРТ ХОЁР СОНГОЛТ БАЙНА

“Эрдэнэс Тавантолгой”-н ногдол ашгийн дийлэнхийг төр хамна

✍ Б.Баяртогтох, ЗГМ сонин

**Т**авантолгой тойрсон улс төр намжих шинжгүй байна. Сонгууль ойртох тусам уг төслийг мэрсэн ажиллагаа идэвхжиж, ярвигтай болдог. Тэр жишгээр Тавантолгойн IPO дахин гацсан. Эргэн сануулахад, 2011 оноос хойших үе үеийн Засгийн газрын мөрөөдлийн жагсаалт дотор Тавантолгой үргэлж байв. 10 жилийн турш дуншиж буй төсөлд хүсвэл хясна гэгч болж байна. Өөрөөр хэлбэл, улс төрөө даалгүй Тавантолгойн IPO замаасаа хэдийн гарлаа. Шинэ Засгийн газрын хийх ажил болон үлдэж байна. Уул уурхайн түүхий эдийн оргил цаг, уналтын үе аль аль нь “Эрдэнэс Тавантолгой”-н туулсан зам.

У.Хүрэлсүхийн Засгийн газар бүрэн эрхийнхээ хугацаанд IPO хийхгүй гэдгээ зарлаж, олон сая ам.доллар зарсан бэлтгэл ажил зогсонги байдалд шилжсэн. Засгийн газрын “хувь заяа”-тай тэнцэж мэдэх Тавантолгойн IPO хөрөнгө оруулагчдын анхаарлаас ийнхүү холдов. Сонгуулийн үр дүнд ч муу, сайнаар нөлөөлж чадах мега төсөл бол Тавантолгой. Эрх баригчид эдийн засгийн

ач холбогдлыг нь хэдийн мэдэх боловч сонгуулийн өмнө хаширлаж, эхлүүлсэн ажлаа дуусгалгүй үлдээлээ. Дэлхий нийтийг түгшээсэн COVID-19 вирусийн цар тахлын уршиг мөн адил Тавантолгойн IPO хойшлох нэг үндэслэл болохоор байв.

**ЯМАР Ч ХУВЬЦААТ КОМПАНИ АШИГТАЙ АЖИЛЛАСАН БОЛ НОГДОЛ АШИГ ТАРААХ ЭСВЭЛ КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХИЙХ, ӨР ТӨЛБӨРӨӨ БАРАГДУУЛАХ АЛХАМ ХИЙДЭГ.**

Төрийн өмч давамгайлсан, олон нийтийн засаглалтай “Эрдэнэс Тавантолгой” 2019 онд нэг тэрбум ам.долларын орлого олж, нэг их наяд төгрөгийн цэвэр ашигтай ажилласан. Тус компанийн түүхэнд байгаагүй өндөр борлуулалт, ашигт ажиллагаа энэ. Тиймээс 1072 хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг тараахаа Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд мэдэгдэж, нэгж хувьцаанд 90 төгрөг буюу 1072

ширхэг хувьцаатай иргэнд 96,480 төгрөг очихоор байна. Компани 2.5 сая хувьцаа эзэмшигчтэй боловч төр нийт хувьцааных нь 80 гаруй хувийг дангаараа атгаж буй.

Ирэх сард тараах нэг их наяд төгрөгийн 800 орчим тэрбумыг төр авна гэсэн үг. Үлдэж буй нь иргэн, аж ахуйн нэгжид ногдох юм. Цар тахлын үеийн эдийн засгийн хүндрэлтэй нүүр тулж байгаа Засгийн газарт ногдол ашгаараа төсвийн алдагдлаа нөхөх эсвэл хуримтлал үүсгэх хоёр сонголт байна. Энэ оны эхний гурван сарын байдлаар төсвийн орлого 270 гаруй тэрбум төгрөгөөр дутсан. “Эрдэнэс Тавантолгой”-н хамгийн том хувьцаа эзэмшигч нь төв бөгөөд энэ утгаараа ногдол ашгийн дийлэнхийг хамна. Ногдол ашиг болох 800 тэрбумаа төмөр замын төсөлд үргэлжлүүлэн зарцуулах эсвэл нүүрс баяжуулах үйлдвэрт зарцуулах эрх нь төрд мөн бий.

1072 хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах холбооноос өмнө нь удаа дараа “Эрдэнэс Тавантолгой” болон Засгийн газар, УИХ-д шаардлага тавьж, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах, ногдол ашиг хуваарилах асуудлыг бүтэн жилийн турш хөндөж ирсэн. Үүний үр дүн гарч, 2012 оноос хойш нэр

төдий хувьцаатай байсан иргэд өнөөдөр ногдол ашгийнхаа үр шимийг хүртэхээр болж буй. Ямар ч хувьцаат компани тухайн жил ашигтай ажилласан бол ногдол ашиг тараах эсвэл компанийн үйл ажиллагаанд хөрөнгө оруулалт хийх, өр төлбөрөө барагдуулах алхам хийдэг. “Эрдэнэс Тавантолгой” тэдний нэг.

Монгол Улсын өрх болгонд хамаатай тус компанийн хувьд өр төлбөрөө барагдуулахад зогсохгүй 2018 оны цэвэр ашгаа төмөр замын төсөлд зориулсан. Харин 2019 оны ашгаа хувьцаа эзэмшигчдэдээ хүртээхээр болсон билээ. Эргэн сануулахад, 2017, 2018 онд тус компани 1.2 их наяд төгрөгийн цэвэр ашигтай ажилласан. Иргэд “Эрдэнэс Тавантолгой”-н нийт хувьцааны 15 хувийг эзэмшиж байна. Хувьцаа эзэмшигчдийн дунд явуулсан судалгаагаар иргэдийн 80 гаруй хувь нь бэлэн мөнгөөр ногдол ашгаа авахаар хандсан тооцоо бий. Нүүрсний зах зээлийн үнэ сайн байгаад зогсохгүй экспорт 2019 онд саатаагүй нь нэг их наяд төгрөгийн ногдол ашиг хуваах “хөрс”-ийг бүрдүүлсэн юм. Харин 2020 онд “Эрдэнэс Тавантолгой” хэдий хэмжээний ашигтай, алдагдалтай ажиллах эсэх нь тодорхой бус байна. ■



# Ноолуурын үнийг яам биш зах зээл тодорхойлно

Тансаг хэрэглээний зах зээл агшиж байна

Б.Мөнх-Эрдэнэ, ЗГМ сонин

Эдийн засгаа дэмжих үүднээс Засгийн газар ноолуурын бэлтгэлд зориулж 300 тэрбум төгрөгийн санхүүжилтийг Хөгжлийн банкаар дамжуулан олгохоо мэдэгдсэн. Ямаа самнах цагаар яах аргагүй нүдээ олсон дэмжлэг энэ. Ноолуурын түүхий эд бэлтгэх, нөөц бүрдүүлэх, үнийг тогтвортой байлгах гэсэн төрийн оролдлого. Гэхдээ ноолуурын үнийг засаг биш зах зээл л тодорхойлно. Үндэсний үйлдвэрүүдэд дээрх мөнгөөр хөнгөлөлттэй зээл олгох гэж буй. Гэвч салбарын сайд нь ноолуурын үнийг 100 мянган төгрөгөөс доош буулгахгүй гэж мэдэгдсэн нь малчдын дунд хүлээлт үүсгэжээ. Нөгөө талдаа түүхий эдээ бэлтгэх гэсэн дотоодын үйлдвэрлэгчдэд энэ нь томоохон дарамт авчраад байна. Сайдын үгийг зах зээл дэнсэлнэ.

Ноолуурын нөөц бүрдүүлэхэд 300 тэрбум төгрөг хангалттай их мөнгө биш. Гэхдээ нэмэр болох нь дамжиггүй. Дэлхий нийтээр тансаг хэрэглээний зах зээл агшиж, аялал жуулчлалын салбар хумигдаж байна. Манай улсыг зорин ирэх жуулчдын тоо энэ онд эрс багасаж, ноолууран бүтээгдэхүүний борлуулалт сайнгүй байх нь. Өөрөөр хэлбэл, үндэсний үйлдвэрлэгчид хүндхэн байдалд орж болзошгүй байна. Ноолууран бүтээгдэхүүний томоохон худалдан авагчид нь жуулчид төдийгүй гаднын зах зээл байдаг.

Бүсээ чангалж буй дотоодын иргэдийн хувьд хямралаар ноолууран бүтээгдэхүүн худалдан авахаас илүү мах, гурил гээд өдөр



Гэрэл зургийг С.Батсайхан

тутмын ахуйн хэрэгцээ болсон хоол хүнсээ хангахыг чухалд тооцно. Ноолуур стратегийн түүхий эд боловч өнөөдрийн нөхцөл байдал бүхнийг өөрчилж байна. COVID-19 вирусийн тархалтаас үүдэн ноолуурын салбарын идэвхжил дэлхий даяар бүхэлдээ саарах болов. Эрэлт байхгүй бол нийлүүлэлт хийх боломжгүй. Дотоодын үйлдвэрлэгчид энэ онд худалдан авсан ноолуурынхаа 20

хувийг нь угааж, 40 хувийг самнаж, үлдсэн 40 хувиар нь 2.4 сая ширхэг бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэхээр төлөвлөсөн.

**Энэ оны хувьд 3-4 мянган тонныг үндэсний үйлдвэрүүд авахаар тооцжээ.**

2.4 сая ширхэг бэлэн бүтээгдэхүүний борлуулалт хэр байхыг хэлж мэдэхээргүй нөхцөл байдал өнөөдөр үүсэж байна. Үүнээс гадна ноолуурын салбар дэмжлэг үзүүлэх нь малчдаа төдийгүй үйлдвэрлэгчдээ аврах боловч байгаль орчинд үзүүлж буй сөрөг нөлөөллийг дурдахгүй өнгөрч боломгүй. Мал сүргийн бүтцэд зонхилох ямааны тоо толгойг төр угтаа дэмжсээр. Бэлчээрийн даац хэтэрч, хомсдол нүүрлэсээр байгаа бус уу.

Ноолуурын салбарт 300 тэрбумын хөнгөлөлттэй зээл олгосонтой холбогдуулан бусад салбарынхан ч мөн адил яагаад бидэнд байдаггүй билээ гэх барьцах хандлага гараад эхэлсэн. Хөдөө аж ахуйн бирж энэ сараас ирэх

сар хүртэл ноолуурын төвлөрсөн дуудлага худалдаа орон нутагт зохион байгуулахаар төлөвлөж байсан ч үүнийгээ хойшлуулж байна. Манай улс жилд 10 мянган тонн ноолуур бэлтгэдэг. Энэ оны хувьд үүний 3-4 мянган тонныг үндэсний үйлдвэрүүд авахаар тооцсон. Ноолуурын дундаж ханш өнгөрсөн онд 127 мянган төгрөг болж өссөн бол. 2020 оны хувьд үүнээс илүү гарах эсвэл буурах ч эрсдэлтэй бөгөөд зах зээл л эцсийн хариулт өгөхөөр байна. Монгол Улс дэлхийн ноолуурын зах зээлийн 40 хувийг бүрдүүлж ирсэн. Хөдөө аж ахуйн биржийн зүгээс ноолуураа бодит үнэ тогтох хүртэл хадгал гэж малчдад урилах болов. Нөгөөтэйгүүр малчид ноолууртай залгаж байж мөнгөтэй болдог. ■



## АМЧАМ МОНГОЛЫН ЦАХИМ БИЗНЕС УУЛЗАЛТААР COVID-19 ЦАР ТАХЛЫН ЭДИЙН ЗАСГИЙН ҮР НӨЛӨӨГ ХЭЛЭЛЦЛЭЭ

Улаанбаатар, Монгол Улс 2020 оны гуравдугаар сарын 31-ний өдөр Монгол дахь Америкийн Худалдааны Танхим (АмЧам Монгол)-ын зохион байгуулсан цахим Бизнес уулзалтад Монгол Улсын Сангийн дэд сайд Х.Булгантуяа, Монголбанкны Ерөнхийлөгчийн зөвлөх, ерөнхий эдийн засагч Д.Ган-Очир нар зочин илтгэгчээр оролцож, Covid-19 цар тахлын эдийн засгийн үр нөлөө болон Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээний талаар мэдээлэл хийлээ. Covid-19 цар тахлын улмаас, Монгол Улс болон дэлхий дахинд олон бизнес зээлээ эргүүлэн төлөх, гэрээт үүргээ биелүүлэх болон ажилчдынхаа цалин, нийгмийн даатгалыг төлөх боломжгүй болж, тэдэнд Засгийн газрын зүгээс бэлэн мөнгөний яаралтай дэмжлэг үзүүлэх шаардлагатай байна. Дэлхийн бусад улс орны Засгийн газрууд болон бодлого боловсруулагчид энэхүү цар тахлын улмаас учирч буй эдийн засгийн үр нөлөөнөөс бизнесүүд болон ард иргэдээ хамгаалах зорилгоор шийдвэртэй алхмууд хийж байна.

Энэхүү цахим уулзалтад АмЧамын гишүүн байгууллагуудын төлөөлөл, дотоод болон гадаадын бизнес эрхлэгч, болон олон улсын байгууллагын төлөөлөгчийн газруудын төлөөллүүд оролцлоо. АмЧам Монголын ТУЗ-ийн дарга Жэй Лиотта тус уулзалтыг нээж хэлсэн үгэндээ, "АмЧам Монгол нь Covid-19 цар тахал Монгол Улсад дэгдэхээс сэргийлэн шаргуу ажиллаж буй нийт эмч, эмнэлгийн ажилтнуудад маш их талархаж буйгаа илэрхийлэв. Монгол Улс энэхүү цар тахлаас урьдчилан сэргийлэх талаараа дэлхийн олон орны тэргүүн эгнээнд явж байна. Харин одоо эмнэлгийн ажилтнуудын заавар, зөвлөмжийн дор хаагдсан бизнесүүдээ аажмаар нээж, улс

орноо буцааж ажилд нь оруулах, бизнесийн үйл ажиллагааг шат дараатай дахин эхлүүлэх боломжийг судлах хэрэгтэй" гэжээ.

Уулзалтын үеэр Сангийн дэд сайд Х.Булгантуяа Монгол Улсын Засгийн газраас өнгөрсөн 7 хоногт зарласан улс орны эдийн засгийг тэтгэх бодлогын арга хэмжээний талаар дэлгэрэнгүй танилцуулж, гадаад худалдаа, хөрөнгө оруулалтын чиглэлд баримталж буй бодлогын талаар мэдээлэл өгч, тулгамдаж буй асуудлаар санал солилцлоо. Сангийн дэд сайд Х.Булгантуяа хэлэхдээ, "Монгол Улсын Засгийн газраас Covid-19 цар тахлыг даван туулах чиглэлээр Засгийн газраас зарласан таван их наяд төгрөгийн бодлогын багц арга хэмжээг санхүүжүүлэхэд шаардлагатай хөрөнгө, санхүүгийн дэмжлэг, туслалцаа авах талаар ОУВС болон бусад олон улсын санхүүгийн байгууллагуудтай хамтран ажиллаж байна" гэв.

Монголбанкны Ерөнхийлөгчийн зөвлөх, ерөнхий эдийн засагч Д.Ган-Очир "Төв банк дунд хугацаанд цар тархалтын дэгдэлтийн нөхцөл байдал муудсан тохиолдолд тус улсын банк, санхүүгийн салбарт учирч болзошгүй эрсдлийг үнэлэх, бууруулах арга хэмжээг авч ажиллаж байна" гэж мэдэгдэв.

Товч мэдээллийн дараа зочин илтгэгчид цахим уулзалтад оролцож буй бизнесийн төлөөллүүдийн сонирхсон асуултаудад хариулсан бөгөөд уулзалтын төгсгөлд АмЧам Монголын Санхүүгийн салбарын хорооны дарга зочид Засгийн газраас авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар чухал мэдээллүүд өгч, өөрсдийн байр сууриа илэрхийлсэнд талархал илэрхийлж, АмЧам Монгол нь Covid-19 цар тахлын дэгдэлтийг бууруулахад Засгийн газрын хүчин зүтгэлийг дэмжиж ажиллахаа илэрхийлэв.



### АМЧАМ МОНГОЛЫН ТУХАЙ

• АмЧам Монгол нь АНУ-Монгол Улс хоорондын бизнесийн түншлэлийг өргөжүүлэх, бэхжүүлэх, эрх ашгийг нь хамгаалах болон Америкийн хөрөнгө оруулалтыг Монголд татах чиглэлээр ажилладаг бие даасан, гишүүддээ үйлчлэх төрийн бус байгууллага юм.

• АмЧам Монгол нь гурван сая гаруй гишүүдтэй дэлхийн хамгийн том бизнесийн холбоонд тооцогддог Америкийн Худалдааны Танхимын албан ёсны салбар юм. Мөн АмЧам Монгол нь Ази Номхон далайн 29 орон Америкийн худалдааны танхимуудыг нэгтгэдэг Ази Номхон далайн орнуудын Америкийн Худалдааны Танхимуудын Зөвлөл байгууллагын гишүүн юм.

Б.Батманлай, Шинжээч


**Д**элхийн банкнаас Зүүн өмнөд Ази, Номхон далайн бүсийн 2020 оны эдийн засгийн тайлан, төлвийг танилцуулсан. Урьдчилан тооцоолоход цар тахлын түвэгтэй үед гарсан хэдий ч уг тайланг эдийн засагчид онцгой анхаарч байна. Монголын эдийн засгийн өсөлтийн суурь төсөөллийг 2.4 хувь гэж тооцоолсон ч Хятадын нөхцөл байдлаас шалтгаалан нэг хүртэл хувьд буурч болзошгүй гэж үзсэн. Тиймээс эдийн засагт авах арга хэмжээнүүд болон цаашдын нөхцөл байдлын талаар Дэлхийн банкны эдийн засагч Б.Даваадалайтай ярилцлаа.



**-Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах ажил нэгдүгээрт тавигдаж, дараа нь эдийн засгийн эрүүл мэндийн асуудал чухал болж байна. Улс орнууд мөнгөний болон төсвийн бодлого хосолсон арга хэмжээ авч хэрэгжүүлж, Монгол Улс ч 5.1 их наяд төгрөгийн дэмжлэг үзүүлэх шийдвэр гаргасан. Энэ асуудалд та ямар байр суурьтай байгаа вэ?**

-Дэлхийн банкны тайланд шинэ төрлийн вирусийн нөлөөгөөр эдийн засагт өмнө байгаагүй шинэ арга хэмжээ авч байгааг дурдсан. Улс орон бүр өөрийн онцлогоос хамаарч төсөв, мөнгөний бодлогодоо харилцан адилгүй хандаж байна. Ингэж ялгамжтай хандахыг Дэлхийн банкнаас онцлон сануулсан. **Тайланд улс гэхэд аялал жуулчлалын салбараа онилж, эдийн засгийнхаа гурван хувьтай тэнцэх хөтөлбөр зарласан бол Малайзад хувь хүнд тулгуурласан эрэлтийг дэмжих чиглэлд нийт эдийн засгийнхаа хоёр орчим хувийг төсөвлөж байна. Харин Монгол Улсын хувьд хүлээгдэж буй эдийн засгийнхаа 12 гаруй**

Монголын эдийн засгийн өсөлт (хувиар)



Эх сурвалж: Дэлхийн банк

Дэлхийн банкнаас гаргасан бодлогын зөвлөмж

- Эрүүл мэнд, эдийн засгийн бодлогын шинэчлэл
- Эрүүл мэндийн салбарын чадавхыг дээшлүүлэх
- Төсөв мөнгөний бодлогын зохицуулалт
- Зээлийн нөхцөлийг зөөлрүүлэх
- Худалдааны нээлттэй бодлого баримтлах
- Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа

Эх сурвалж: Дэлхийн банк

## Хямралын эсрэг арга хэмжээ авах нь зөв ч ирэх жилүүдэд анхаарсан эдийн засгийн бодлого чухал

**COVID-19-ийн эсрэг Тайланд, Малайз зэрэг улс эдийн засгийнхаа 2-3 хувьтай тэнцэх хөтөлбөр зарласан бол Монгол Улс 12 гаруй хувийг эзлэх хэмжээний төсөв гаргахаа мэдэгдлээ**



Гэрэл зургийг С.Батсайхан

**хувьтай тэнцэх хэмжээний хөтөлбөр зарласан нь өндөр дүнтэйд тооцогдож байна.** Гэхдээ нарийвчилсан тодорхой мэдээлэл нь олон нийтэд хараахан нээлттэй болоогүй тул нөлөө, үргэлжлэх хугацаа, бусад үзүүлэлтийг урьдчилан тооцоход эрт байна. Зарчмын хувьд гол анхааруулж зөвлөх зүйл нь эдийн засгийн гадаад сектор, төлбөрийн тэнцэл, инфляц, болон дархлаа, эмзэг байдалд нийцтэй хэлбэрээр энэ арга

хэмжээг авч хэрэгжүүлэх нь чухал юм. Мэдээж Засгийн газар тооцоо судалгаагаар хандсан байх.

Коронавирусийн нөлөөллийг зөөлрүүлэх тал дээр арга хэмжээ авах нь зөв, гэхдээ өмнө нь хэрэгжүүлж байсан бодлогын шинэчлэлээ тууштай үргэлжлүүлэх нь чухал. Яагаад гэвэл ирэх оноос Засгийн газар, хувийн хэвшлүүд ч гэсэн том хэмжээний төлбөр хийж эхэлнэ. Хамгийн эхний жишээ гэхэд энэ

оны тавдугаар сард ХХБ-ны 500 сая ам.долларын бондын эргэн төлөлт хийнэ. Эдгээр асуудалтай холбоотой сая зарласан бодлогын арга хэмжээ эдийн засагт хэр нийцтэй вэ, зарим сөрөг нөлөө үзүүлэхгүй тал дээр анхаарах хэрэгтэй. Зарчмын хувьд эдийн засгийн дархлаагаа хамгаалж, энэ удаагийн COVID-19-өөс шалтгаалсан хүндрэлээр зогсохгүй ирэх жилүүдэд чиглэсэн бодлогоо анхаарч,

хөрөнгө оруулагчдын итгэлийг алдахгүй байхыг чухалчлах нь зөв юм болов уу.

**-Гал унтраах шийдвэрээс илүү төлөвлөгөөтэй хандах нь чухал байгааг эдийн засагчид хэлж байна. Гэвч сангийн орон зай маань хязгаарлагдмал шүү дээ?**

-Засгийн газар төсөвт тодотгол хийхгүй, зардлаа хэмнэх, төсвийн мөнгөний сангийн удирдлагыг оновчтой болгох, дотоод өр авлагаа цэгцлэх, гадны зээл тусламжийн хуваарилалтаа эргэж харах мэтээр өөрчлөлт хийнэ гэж ойлгосон. Засгийн газар өнгөрсөн хоёр жилд төсөв ашигтай гаргасан, нийгмийн даатгал болон бусад зүйлд зоригтой шинэчлэл хийсэн амжилттай. Эдгээр шинэчлэл одоо энэ хямралын сөрөг нөлөөг харьцангуй бууруулж байж болзошгүй. Ямар ч тохиолдолд эдийн засгийн шинэчлэл хийх нь хямралын буюу хүндрэлтэй үед орон зайгаа алдахгүй давуу талтай.

Нөгөө талаас уул уурхайн түүхий эдийн үнэ буурч, төсвийн орлого тасрах эрсдэл үүссэн байна. Ийм үед эдийн засгийнхаа арав гаруй хувьтай тэнцэх хэмжээний хөтөлбөр зарлачихсан байна. Магадгүй цаашдаа төсвийн тодотгол хийх байх. Тодотгол хийхэд тусгай хууль гаргадаг шүү дээ. Засгийн газар хуульд захирагдаад, нарийн төлөвлөгөөтэй ажиллах байх.

**-Энэ удаагийн хүндрэл цаашдаа хямралд хүргэх нь гэсэн болгоомжлол бий. Хувийн хэвшил гол эрсдэлийг нуруундаа үүрч байна. Ажилгүйдэл ихсэж, дагаад ядуурлын хэмжээ өсөх хандлагатай боллоо. Таны төсөөлөл ямар байна?**

-Баялаг бүтээгчид буюу хувийн секторынхныг ихээхэн дэмжих бодлого бусад орны зүгээс ч барьж байна. Монголын манай Засгийн газар ч ийм алхам хийлээ. 2018 онд Дэлхийн банкнаас гаргасан ядуурлын үзүүлэлтийн тайланд эдийн засгийн ямар нэг хүндрэл, томоохон шок орж ирэхэд богино хугацаанд ядуурлын тоо нэмэгдэх эрсдэл байгааг анхааруулсан. Энэ удаад ажлын байрыг хамгаалж, ядууралд аль болох өртөхгүй байхад анхаарах хэрэгтэй. Зорилтот бүлэгт чиглэсэн, байгаа оносон бодлого явуулах нь чухал байна. ■

УУЛ УУРХАЙ

### Ханаду Mines удирдлагын зардлаа 35 хувиар танана

Т.Элиса, Шинжээч

Ханаду Mines компани үйл ажиллагааныхаа талаар мэдээллээ. Тус компанийн гол төсөл болох Өмнөговь аймгийн нутагт орших Хармагтай ордын алмазан өрөмдлөгийн ажил хоёрдугаар сард зогссон байна. Мөн тус компани 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөгөө эргэн нягталж, чухал биш гэж

үзсэн ажлуудаа цуцлах буюу хойшлуулжээ. Улмаар 2020 оны удирдлагын зардлаа 2019 оныхтой харьцуулахад 1.3 сая австрали доллараар буюу 35 хувиар танахаар зорьж байна.

Өнгөрсөн онд Ханаду Mines компани зардлаа 20 хувиар танаж байжээ. Тус компанийн бэлэн мөнгөний тэнцэл 2020 оны хоёрдугаар сарын байдлаар 2.8 сая австрали доллар байна.

Мөн Дорноговь аймгийн нутагт орших зэс, алтны порфирийн Red Mountain буюу "Улаан уул" төслийнхөө хайгуулын ажилд зориулж Японы Газрын тос, хий, металлын үндэсний корпорацитай 7.2 хүртэлх сая ам.долларын санхүүжилт татах гэрээ байгуулжээ. Үүний зэрэгцээ энэхүү төслийн хайгуулын ажлыг 2020 оны IV, V сард эхэлж, XI сар хүртэл үргэлжлүүлэхээр төлөвлөжээ. ■

ТҮҮХИЙ ЭД

### Ноолуурын үнэ 60 мянга болж буурсан гэв

Ноолуур бэлтгэлийн улирал гэгддэг гуравдугаар сард Хөдөө аж ахуйн бирж ноолуур арилжаагүй байна. Он гарснаас хойш тус биржид нийт 860 кг ямааны ноолуурыг дунджаар 91 мянган төгрөгөөр арилжжээ. Тэгвэл өнгөрсөн оны гуравдугаар сард Хөдөө аж ахуйн биржид нийт 4.6 тэрбум төгрөгийн ноолуур арилжиж байсан, жигнэсэн дундаж үнэ нь 134 мянган

төгрөг байжээ. Харин энэ онд эрэлт талын саатал үүссэнээс ноолуурын үнэ 60 мянга хүрч буурсныг Монголын ноос ноолуурын холбоо мэдээлсэн юм. Дотоодод жилд дунджаар 10 мянган тонн ноолуур бэлтгэдэг. Харин Хөгжлийн банкнаас өгөх 300 тэрбумын хөнгөлөлттэй зээлээр дотоодын үйлдвэрлэгчид дунджаар 3000 тонн ноолуур худалдан авах чиглэлтэй. ■

# Азийн цагаан будааны экспортод хүндрэл учирч эхэллээ

Ли Хису

Дэлгүүрийн лангуу хоосолж аюулгүйн нөөц бэлдэх явдал хүнсний хангамжид занал учруулж буй цаг үед боломжийн үнээр хоол хүнсээ залгуулах нөхцөл иргэддээ бүрдүүлэх нь улс төрийн тогтвортой байдлыг хангахад амин чухал гэдгийг засгийн газрууд ухамсарлаж байна.

ОХУ, Казахстан, Украин улаан буудайн экспортоо хязгаарлалт тогтоох гэж буйгаа хэдийн зарласан. Харин Ази тивийн хувьд хүнсний хангамж тасалдах вий гэсэн түгшүүр нь бүс нутгийн олон тэрбум хүний үндсэн амин зуулгын үндэс – цагаан будаатай холбоотой. Учир нь БНХАУ, Энэтхэг улс дэлхийд цагаан будааны гол үйлдвэрлэгч төдийгүй хэрэглэгч нь болдог.

Дэлхийн цагаан будааны гурав дахь гол ханган нийлүүлэгч Вьетнам улс Меконг мөрний бэлчирт ган болж, дотоодын эрэлтээ түрүүлж хангах шаардлага тулгарснаас экспортоо түр зогсоогоод байна. Нийлүүлэлт тасалдахаас болгоомжилж буй Мьянмар экспортоо багасгаж болзошгүй гэдгээ анхаарууллаа.



Филиппиний нийслэлийн Валенсуэла дахь Үндэсний Хүнсний Захиргааны агуулахад цагаан будаа буулгаж байгаа нь.

Бангкок дахь НҮБ-ын Хүнс, Хөдөө Аж Ахуйн Байгууллагын төлөөлөгч, тутрагын эдийн засаг судлаач Дэвид Доу “улс орнууд хэрээс хэтэрсэн болгоомжтой ажиллаж байгаа”-г дурдав. “Бүгд л эхлээд дотооддоо хангалттай нөөцлөх хүсэлтэй” хэмээн тэрбээр тайлбарласан юм.

Импортлогч улсууд ч боломж бүхнийг “шүүрч байна”. Вьетнамын экспортын гол зах зээл, хүнсний хангамжийн санаачилгад 600 сая ам.доллар хуваарилаад буй Филиппин 300 мянган тонн цагаан будаа импортлохоор төлөвлөжээ. Тус улс цагаан будааг засгийн газрын хэлцлийн түвшинд Зүүн өмнөд Азийн ханган

**ЦАГААН БУДААНЫ УРГАЦ 2019-2020 ОНД ДЭЛХИЙ ДАЯАР ҮНЭМЛЭХҮЙ ИХ БУЮУ 500 САЯ ТОНН ХҮРЧ, НӨӨЦИЙН ХЭМЖЭЭ УРЬД ӨМНӨ БАЙГААГҮЙГЭЭР ИХСЭН 180 САЯ ТОННЫГ ДАВААД БАЙНА.**

нийлүүлэгчдээс, эсвэл Энэтхэг, Пакистанаас авах бололтой.

Нийт 1.4 тэрбум хүнийг тэжээж буй БНХАУ-д цагаан будаа нь хэдэн зууны турш хүнсний бодлогын суурь болж ирсэн юм. Зарим үр тарианы худалдан авах үнийг өсгөөд буй тус улс ахиу нөөц бэлтгэх үүднээс энэ оны ургацаас үнэмлэхүй хэмжээгээр худалдаж авахаа мэдэгдлээ. **Дотоодын хэрэглээнд нь импорт, экспортын нөлөө бараг байхгүй БНХАУ коронавирусууд үүдэн эдийн засаг хямарсан үед цагаан будааны ахиу нөөцтэй байхыг эрмэлзэж байна.**

Бодит байдал дээр хомсдол үүсээгүй. Экспортоор дэлхийд тэргүүлэгч Энэтхэгийн агуулахууд үнэмлэхүй ургац хураасантай

уялдан цагаан будаа, улаан буудайн нөөцөөр дүүрлээ. Цайруулсан тутарга буюу цагаан будааны ургац 2019-2020 онд дэлхий даяар үнэмлэхүй их буюу 500 сая тонн хүрч, нөөцийн хэмжээ урьд өмнө байгаагүйгээр ихсэн 180 сая тонн даваад байгааг АНУ-ын Хөдөө Аж Ахуйн Яам тооцоолжээ.

Цагаан будааны экспортоор дэлхийд хоёрдугаарт орж буй Тайланд сүүлийн олон арван жилд тохиолдоогүй ган гачгийн дараа ч экспортын төлөвлөгөө биелэхүйц хангалттай нөөцтэй байна. Дэлхийд хүн амын тоогоор дөрөвдүгээрт ордог Индонез хэдийн дотоодын хангалттай нөөцтэй болсноо мэдэгдэв. ■


## Коронавирус тархаж буйг эрт тодорхойлох шинэ арга нээжээ

Жэйсон Гэйл

Хүрээлэн буй орчноос сорьц авах судалгаа нь цар тахлаас сэргийлэх клиник тандалт судалгаанд үр дүнтэй болж чадахаар байна. Нидерландын эрдэмтэд COVID-19-ийн халдварын тохиолдол бүртгэгдэхээс бүр өмнө хотын бохирын уснаас коронавирус илрүүлж чадсан нь уушги үрэвсүүлэгч өвчний аюулаас эрт сэрэмжлүүлэх систем бүтээх боломжтойг харуулав.

SARS-CoV-2 гэгддэг коронавирус нь халдвартай хүний өтгөнөөр дамжин гадагшилдаг. **Бохирын сүлжээ халдвар дамжуулах магадлал бага ч хүн амын дунд халдвар ихсэх тохиолдолд бохир ус дамжуулах хоолойноос илрэх коронавирусын хэмжээ уялдан ихэснэ** гэдгийг Нидерландын Нивегейн дэх KWR Ус судалгааны хүрээлэнгийн профессор Гертян Медена хамтран зүтгэгчдийнхээ хамт даваа гарагт мэдэгдлээ.

Эрдэмтэд коронавирусын генийн материалыг Нидерландын



нийслэлээс зүүн урагш 50 километр оршдог Амерсфорт хотын хаягдал ус цэвэрлэх үйлдвэрээс гуравдугаар сарын 5-нд буюу тус хотод өвчний тохиолдол бүртгэгдээгүй байхад илрүүлсэн юм. COVID-19-ийн анхны тохиолдол Нидерланданд хоёрдугаар сарын 27-нд бүртгэгдсэнээс хэдхэн хоногийн дараа улс орны өмнөд хэсэгт эрүүлийг хамгаалахын ажилтнууд өвдөж эхэлсэн нь халдвар улс орныг хамарсны илрэл болжээ.

“Бохирын шугамаас илэрч буй коронавирусын талаарх

мэдээлэл цуглуулж, ус сувгийн ажилтнуудад эрсдэлтэй эсэхийг магадлах, олон нийтэд SARS-CoV-2 коронавирус тархаж буйг мэдэхэд бохирын сувгийн мониторинг-хяналт ашиглаж болох эсэхийг тодорхойлох нь чухал” хэмээн профессор Медена мэдэгдэв. Ашиглаж болох аваас шинэ арга нь “COVID-19-өөр халдварласан онцгой хурц илрэл бүхий өвчтнүүдээр хязгаарлагдаж буй өнөөгийн клиник тандалт судалгаанд нөхвөр болж чадна” хэмээн эрдэмтэн тайлбарласан юм. ■

## Дөрөвдүгээр сарын донсолгоо олон жилийн урхагтай

Бен Шарплес

Газрын тосны эрэлт энэ сараас түүхэнд тохиолдоогүйгээр муудах шатанд шилжиж байгаа нь цаашдын он жилүүдэд олборлох үйлдвэрлэлийн дүр төрхийг өөрчилж болзошгүй.

Дөрөвдүгээр сард газрын тосны өдрийн хэрэглээ жилийн өмнөх үетэй харьцуулахад 15-22 сая баррелиар унах тооцоог дэлхийн эрчим хүчний нөлөө бүхий судлаачид гаргаад байна. Хямралт нөхцөлөөс шалтгаалан нэрэх үйлдвэрүүд хаалгаа барьж, өрөмдлөг зогсон, хадгалах савнууд дэлхий даяар дүүрч эхлэв.

ОПЕК+ эвсэлд холбоотон байсан Саудын Араб, ОХУ хоёр зах зээлд эзэлдэг байр сууриа алдахгүйн төлөө

олборлолтоо чадлаараа ихэсгэж, төмөр зам болон далайн, мөн дамжуулах хоолойн тээвэрт нэмэлт дарамт үүсгэж, эрэлтийг бүр ч муутгалаа.

Энэ дөрөвдүгээр сард хадгалах савнуудад 20 сая баррель газрын тос цутгах тооцоог Goldman гаргасан бол HIS Markit оны дунд үе гэхэд газрын тос хадгалах багтаамж дэлхий даяар хүрэлцэхгүй болно гэж үзэж байна.

Нисэх онгоцны шатахууны эрэлт дөрөвдүгээр сард мөн л үнэмлэхүй буурна. Консалтингийн FGE фирмийн тооцоогоор АНУ-ын бензиний хэрэглээ энэ сард жилийн өмнөх үеэс 50 хувиар унана.

**Цаашид газрын тосны дэлхийн бенчмарк Brent-ийн үнэ баррель нь 10 ам.доллар орчимд хүрч болзошгүй хэмээн Energy Aspect Ltd таамаглав. ■**

**А**з болж МакКензи Безос ямбатай эмэгтэй байсангүй. Учир нь 1996 онд Amazon-ы төв байранд ямбалан суух цаг, зав байсангүй. Тэрбээр тал хэсгийг нь гал тогооны өрөө болгон тохижуулсан оффистоо залуу ажилчдын хамт ажилладаг байв. Түүнийг өдөрт 12 цагийн турш санхүүгийн тооцоо гаргаж байх зуур ойр хавиар нь ажилтнууд чихцэлдэн орж, богино долгионы зуух ашигладаг байжээ. Харин шөнө болоход тэрбээр агуулахын байранд очиж, захиалсан бараануудыг хайрцагладаг байв. Amazon-ы долоо дахь ажилтан Майк Хэнлон түүнийг “агуу хувь нэмэр оруулсан хүн” хэмээн тодотгож “Тэрбумтны эхнэр болоход авьяас чадвар бүдгэрдэг бол МакКензигийн авьяас гялалзсаар байсан” хэмээв.



⊖ **Алдарт хос Жефф, МакКензи нар 2009 онд Нью-Йорк хотын Plaza зочид буудалд зохион байгуулсан шагнал гардуулах ёслолын үеэр.**

Өдгөө 49 настай МакКензигийн нууцлаг байдлыг анхнаасаа сайтар боловсруулсан төлөвлөгөө гэлтэй. Amazon-ы эхэн үеэс л нэрээ нууцалсан тэрбээр 2019 оны нэгдүгээр сард Жефф Безосоос гэрлэлтээ цуцлуулах болсон тухай мэдээлэл тархсанаас хойш ч ярилцлага өгсөнгүй. **Гэр бүл цуцлах ажиллагаа долдугаар сард эцэслэхэд МакКензи Amazon компанийн дөрвөн хувийг эзэмшиж үлдсэн юм. Ийнхүү эзэмшдэг хувьцааных нь үнэлгээ 36.1 тэрбум ам.доллараар хэмжигдэж буй тул МакКензи энэ жилийн Forbes 400 эрэмбэд 15 дугаар байрт шууд бичигдэж байна.** Amazon-ы анхны хөрөнгө оруулагчдын нэг Ник Ханауэр “МакКензи компанийнхаа 50 хувийг авах ёстой байсан. Түүнийг

Жеффтэй эн тэнцүү зүтгэсэн гэж хэлж болно” гэв. Хэдийгээр МакКензи нийтлэлийн гол дүр боловч бидэнд ярилцлага өгсөнгүй. Дүрээ илүү тодотгохын тулд найз, нөхөд, хуучин ажлын хамт олон гэх мэт 100 гаруй хүнтэй уулзаж, олон хоног хөөцөлдсөн боловч үнэндээ түүнийг хаалттай боловч авьяаслаг, амьдралынхаа

үе шат болгонд чимээгүйхэн амжилт гаргаж байсан эмэгтэй гэх бүдэгхэн зураглалаас илүү гаргаж чадсангүй. Сан-Францискод өссөн, айлын дунд хүүхэд МакКензи дөнгөж зургаан настайдаа The Book Worm хэмээх 142 хуудастай ном бичиж байжээ. Аав нь санхүүгийн мэргэжилтэн, ээж нь гэрийн эзэгтэй байсан бөгөөд

МакКензи Коннектикут муж дахь дотуур байртай Хочкис сургуулийг нэг жилээр урьдчилж төгсжээ. Улмаар Кембриж, Принстоны их сургуульд англи хэл шинжлэлээр суралцаж, Нобелийн шагналт зохиолч Тони Моррисоноор судалгааны ажлаа удирдуулж байв. Түүнд англи хэл зааж байсан профессоруудын нэг Жефф Нуокава “Тэр ерөнхийдөө даруу,

төлөв зантай, дуугай, авьяаслаг оюутан байв” гэсэн юм. Тэрбээр сургуулиа амжилттай төгссөн D.E. Shaw хөж санд ажиллаж байхдаа Жеффтэй болзож эхэлсэн бөгөөд 1994 онд Amazon-ыг үүсгэн байгуулахын тулд ажлаасаа гарчээ. Түүний оролцоо анхнаасаа маш өндөр байв. “Хэнд ч, ямар ч албан тушаал байгаагүй... Тиймээс МакКензи бараг бүгдийг хийдэг байсан” хэмээн анхны ажилчдын нэг Тод Нельсон дурссан юм.

МакКензи зөгнөлт зохиол бичих ажилдаа шамдан орох үүднээс Amazon-ыг олон нийтэд нээлттэй болсон 1997 онд компанийхаа ажлаас хөндийрчээ. 2005 онд хэвлэлийн компани HarperCollins анхны ном The Testing of Luther Albright-ыг нь хэвлэх хүртэл МакКензи олны анхааралд өртөлгүй явж чадсан юм. Тони Моррисон түүний зохиолыг “ховор бүтээл” хэмээн дүгнэдэг. МакКензигийн дараачийн бүтээл бол 2013 онд хэвлэгдсэн Traps юм.

Харин сүүлийн үеийн амьдралынх нь талаар мэдэх эх сурвалж бараг байсангүй. Жефф, МакКензи нар гэр оронгүй иргэдийг байртай болгох, сургуулийн өмнөх боловсролын төлөөх ашгийн бус байгууллагуудыг дэмжих үйлсэд зориулж хоёр тэрбум ам.доллар хандивлах амлалтыг 2018 онд өгсөн билээ. Түүнчлэн, МакКензи тавдугаар сард гэр бүл цуцлах ажиллагаа дуусах үеэр Giving Pledge амлалтад нэгдэж, хөрөнгийнхөө тэн хагасыг сайн үйлсэд зориулна хэмээн амласан юм. Харин тэрхүү олон тэрбум ам.доллар хэрхэн зарцуулагдахыг МакКензи хэлсэнгүй. **Forbes**

# НУУЦ ТЭРБУМТАН

Amazon-ы анхны цөөн ажилтны нэг, тэрбумтан, зохиолч МакКензи Безос

## ДЭЛХИЙН ХАМГИЙН ЧИНЭЭЛЭГ 10 ЭМЭГТЭЙ

**Forbes-ийн 2019 оны дэлхийн тэрбумтнуудын жагсаалтад дэлхийн олон орноос, төрөл бүрийн салбарыг төлөөлж, 244 эмэгтэй шалгарсан билээ. Өөрөөр хэлбэл, бизнесийн ертөнцөд эмэгтэйчүүдийн эзлэх хувь хэмжээ жилээс жилд тэлж байна. Тиймээс энэхүү урт жагсаалтаас эхний 10-т шалгарсан хамгийн нөлөө бүхий тэрбумтан эмэгтэйчүүдийг танилцуулж байна.**



**1. ФРАНСУАЗА БЕТТАНКУР МАЙЕРС**  
НИЙТ ХӨРӨНГӨ: **\$55.3 ТЭРБУМ**  
НАС: 66  
ХӨРӨНГИЙН ЭХ ҮҮСВЭР: **L'OREAL**  
УЛС: **ФРАНЦ**



**2. ЭЛИС УОЛТОН**  
НИЙТ ХӨРӨНГӨ: **\$53.1 ТЭРБУМ**  
НАС: 70  
ХӨРӨНГИЙН ЭХ ҮҮСВЭР: **WALMART**  
УЛС: **АНУ**



**3. ЖУЛИЯ КОХ, ТҮҮНИЙ ГЭР БҮЛ**  
НИЙТ ХӨРӨНГӨ: **\$42.7 ТЭРБУМ**  
НАС: 57  
ХӨРӨНГИЙН ЭХ ҮҮСВЭР: **KOCH INDUSTRIES**  
УЛС: **АНУ**



**4. МАККЕНЗИ БЕЗОС**  
НИЙТ ХӨРӨНГӨ: **\$34.4 ТЭРБУМ**  
НАС: 49  
ХӨРӨНГИЙН ЭХ ҮҮСВЭР: **AMAZON.COM**  
УЛС: **АНУ**



**5. ЖАКЛИН МАРС**  
НИЙТ ХӨРӨНГӨ: **\$29.8 ТЭРБУМ**  
НАС: 80  
ХӨРӨНГИЙН ЭХ ҮҮСВЭР: **ЧИХЭР, ТЭЖЭЭВЭР АМЬТНЫ ХООЛ ХҮНС**  
УЛС: **АНУ**



**6. ЯН ХУЭЙЯНЬ**  
НИЙТ ХӨРӨНГӨ: **\$25.3 ТЭРБУМ**  
НАС: 38  
ХӨРӨНГИЙН ЭХ ҮҮСВЭР: **ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГӨ**  
УЛС: **ХЯТАД**



**7. ЛОРЕН ПАУЭЛЛ ЖОБС**  
НИЙТ ХӨРӨНГӨ: **\$23.3 ТЭРБУМ**  
НАС: 56  
ХӨРӨНГИЙН ЭХ ҮҮСВЭР: **APPLE, DISNEY**  
УЛС: **АНУ**



**8. СЮЗАННА КЛАТТЕН**  
НИЙТ ХӨРӨНГӨ: **\$20.7 ТЭРБУМ**  
НАС: 57  
ХӨРӨНГИЙН ЭХ ҮҮСВЭР: **BMW, ЭМ ХАНГАМЖ**  
УЛС: **GERMAN**



**9. ШАРЛЕН ДЕ КАРВАЛЬО-ХЕЙНЕКЕН**  
НИЙТ ХӨРӨНГӨ: **\$15.7 ТЭРБУМ**  
НАС: 65  
ХӨРӨНГИЙН ЭХ ҮҮСВЭР: **HEINEKEN**  
УЛС: **НИДЕРЛАНД**



**10. ЭБИГЕЙЛ ЖОНСОН**  
НИЙТ ХӨРӨНГӨ: **\$15.3 ТЭРБУМ**  
НАС: 57  
ХӨРӨНГИЙН ЭХ ҮҮСВЭР: **ХӨРӨНГИЙН МЕНЕЖМЕНТ**  
УЛС: **АНУ**

# Зай талбай хэмнэсэн загварлаг шийдлүүд

✍ С.Дөлгөөн, ЗГМ сонин

**С**үүлийн үед минималист чиг хандлага дэлгэрч дэлхий даяар бага зай талбайтай орон сууцанд тохитой, хэмнэлттэй амьдрах чиг хандлага дэлгэрч буй. Тиймээс хэрхэн орчин үеийн тохилог дизайнтай тохижуулах талаар мэргэжлийн дизайнерууд ухаанаа уралдуулдаг болсон. Хэрвээ танд ийм нөхцөл байдал үүссэн бол дараах мэдээлэлд анхаарлаа хандуулаарай. Эдгээр санааны аль нэгийг хэрэгжүүлснээр гэрээ том зайтай харагдуулаад зогсохгүй илүү тохилог болгож чадна.



## Толь байрлуулах

Жижиг ч бай, том ч бай толь байрлуулбал толины тусгал өрөөг илүү саруулхан гэрэлтэй болгож харагдуулдаг. Тиймээс зурагны оронд чимэглэлийн тольнууд өлгөвөл тухайн орон зайнд илүү том мэт мэдрэмж төрүүлэх болно.

## Том буйдан тавих

Том тавилга өрөөний хамаг зайг эзэлнэ гэж ихэнх хүмүүс санаа зовдог боловч үнэн хэрэгтэй тийм биш. Харин эсрэгээрээ булангын том буйдан олон хүнийг багтаахаас гадна, тохилог орчныг бүрддэг.

## Гайхшруулах хүчин зүйл

Зоригтой шийдэл бүхий хурц хээтэй дэр зураг эсвэл хивс тавибал бусдын анхаарал жижигхэн зочны өрөөнд биш өвөрмөц шийдэл бүхий дэр, хивсэн дээр бууна. Үүнээс гадна гоё хээтэй дэр гэрийг тань илүү сонирхолтой болгож, чимнэ.

## Тэгш шугамыг баримтлах

Тавилга эсвэл зурагнуудыг нэг шугаманд байрлуулах. Ингэснээр гэр орон эмх цэгцтэй, замбараатай харагдахаас гадна илүү том орон зайтай мэт мэдрэмж төрүүлнэ.

## Хананд өлгөдөг тавилга сонгох

Том хөлтэй шүүгээ, шургуулга, зурагтын тавиур зэргийг хананд өлгөдөг тавилгаар сольсноор өрөө илүү зайтай болж өгнө.

## Хана болон буланг ашиглах

Аль нэг өрөө тань гурвалжин хэлбэртэй байх, эсвэл коридорын хана нэг л авцалдаагүй харагдаад байвал хээтэй болон цэцэгтэй ханын цаасаар чимэглээрэй. Ингэвэл хэн ч таны сонин хэлбэртэй коридорыг анзаарахгүй өнгөрөх болно.

## Өвөрмөц болон эртний эдлэл ашиглах

Зочны өрөөндөө ямар нэгэн өвөрмөц декор эсвэл эртний эдлэл тавьснаар зочдын тань анхаарал таны торгон мэдрэмжтэй, байршлыг нь зөв олж тавьсан тэрхүү чимэглэл дээр буух болно. Тухайлбал, морин хуур, бугын эвэр зэргийг өлгөж болно шүү дээ.

## Хана дүүрэн ном

Унтлагын эсвэл зочны өрөөний ханыг бяцхан номын сан болгоорой. Яагаад гэвэл гоё дизайнтай хийсэн номын сан зочдын анхаарлыг татаад зогсохгүй гэрт тансаг уур амьсгал нэмж өгнө.

## Нэг өнгөөр дагнах

Хана цагаан байх тусмаа зайтай харагддаг гэдгийг санаарай. Харин тавилга завсрын өнгөтэй байвал гэрийн чимэглэлтэй илүү зохицно.

## Хөшиг урт байх

Урт хөшиг таазыг өндөр харагдуулна. Тиймээс хөшигөө таазанд тултал өлгөөд газарт бага зэрэг шүргүүлээрэй.

## Аливаа зүйлийг гурав гурваар нь хослуулах

Буйдан дээр хэтэрхий олон дэр байвал гурав болгох, эсвэл зураг, цэцэг, шөнийн гэрэл гурвыг ижил өнгөөр хослуулах зэргээр гурвын дүрмэнд захирагдвал гэр маш эмх цэгцтэй болно.

## Энгийн минималист байх

Хэт их хээ угалз, эрээлжилсэн олон өнгө нүдийг ядрааж, стресс нэмэгдүүлдэг. Та гэртээ байхдаа бухимдаад байвал тавилгуудаа нэг ажиглаад үзээрэй. Хэрвээ эрээлжилсэн олон өнгө байгаа бол ихэнх тавилгуудаа цайвар суурь өнгөтэй болгоод ганц нэг тод өнгө болон металик чимэглэл оруулахад л болно.

## Гэрэл нэмэх

Гэрлийг ашиглан өрөөг том уужуу болгож болно. Тиймээс тааз, ширээ, хана болон шаланд олон янзын гэрэлтүүлэг байрлуулаарай. Ингэснээр гэрэл сайтай өрөө илүү саруулхан, зайтай харагдана.

## Тавиур ашиглах

Таазнаас тогтоодог, өлгөдөг тавиурнууд орчин үеийн сонирхолтой санаа юм. Энэ нь ханатайгаа ойролцоо өнгөтэй байвал илүү зүгээр. Үүнээс гадна цонхны хажуугийн хананд дээр номын тавиур, эсвэл сувинерийн тавиур хийж болно.

## Дүрэм дагах албагүй

Зочны өрөөнд заавал буйдан, ширээ байрлуулах албагүй гэдгийг санаарай. Та хураагддаг ширээ ашиглахад л хангалттай зай хэмнэж чадна. Заавал ширээ тавих хэрэгтэй байвал шилэн ширээ сонгоорой. Шилэн ширээ тунгалаг учир зай эзэлж харагддаггүйгээрээ давуу талтай.

## ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо : 2020 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр

**ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН НЭР:** “Нийслэлийн Эрүүл мэндийн газрын харьяа байгууллагуудын 2020 онд хэрэглэх эм, эмнэлгийн хэрэгсэл” нийлүүлэх-5  
**ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ДУГААР:** НХААГ-20/0004

**Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар нь** эрх бүхий тендерт оролцогчдоос “**Нийслэлийн Эрүүл мэндийн газрын харьяа байгууллагуудын 2020 онд хэрэглэх эм, эмнэлгийн хэрэгсэл-5**”-ийг нийлүүлэх тухай цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү эм, эмнэлгийн хэрэгслийн тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу.

Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө **50,000 /Тавин мянга/** төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **30 хоногийн** дотор хүчинтэй байна.

Тендер нь дараах багцаас бүрдэнэ: Үүнд:

**Багц №44:** Цус бүлэгнэлтэнд нөлөөлөх эмүүд, НХААГ-20/0004-44

**Багц №53:** Эмнэлгийн нэг удаагийн дагалдах хэрэгсэл, НХААГ-20/0004-53

**Багц №56:** Халдваргүйжүүлэх болон үхжлийн эсрэг бодис /Дотоодын үйлдвэр/, НХААГ-20/0004-56

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

Борлуулалтын хэмжээ: **Сүүлийн 2 жил буюу 2018, 2019 онуудын аль нэг жилийн борлуулалтын орлогын хэмжээ нь багц тус бүрийн төсөвт өртгийн 50%-аас багагүй байна.**

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: **Багц тус бүрийн төсөвт өртгийн 30%-аас багагүй байх.**

Сүүлийн хоёр жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг: **Сүүлийн 2 жил буюу 2018, 2019 оны аль нэг жилд багц тус бүрийн төсөвт өртгийн 30 хувиас багагүй, үнийн дүнтэй ижил төстэй эм, эмнэлгийн хэрэгсэл нийлүүлсэн байх.**

Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл ирүүлэх эсэх: **Шаардлагатай**

Монгол Улсын Эрүүл мэндийн яамнаас олгогддог:

Хүний эм, эмнэлгийн хэрэгсэл импортлох, ханган нийлүүлэх, худалдах тусгай зөвшөөрөл.

Хүний эм, эмнэлгийн хэрэгсэл үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл.

Тендерийн хамт дараах тендерийн баталгаа ирүүлнэ. Үүнд:

**Багц №44:** 1,200,000 /нэг сая хоёр зуун мянга/ төгрөг

**Багц №53:** 2,150,000 /хоёр сая нэг зуун тавин мянга/ төгрөг

**Багц №56:** 570,000 /таван зуун далан мянга/ төгрөг

Цахим тендерт оролцогч цахим баталгаа гаргах эрх бүхий арилжааны банкаар цахим тендерийн баталгаа гаргуулна.

Тендерийг **2020 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 11 цаг 00 минутаас өмнө** системд ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2020 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 11 цаг 50 минутад** Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын 1012 тоот өрөөнд нээнэ. Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй.

Дотоодын давуу эрх тооцно.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Бага тойруу-15, Самбуугийн гудамж,**

**Нийслэлийн Засаг захиргааны 4 дүгээр байр, 10 дугаар давхар,**

**Нийслэлийн худалдан авах ажиллагааны газар,**

**Утас: 75757807**

**Цахим хаяг: [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn), [www.ub-procurement.mn](http://www.ub-procurement.mn)**

## ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо : 2020 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр

**ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН НЭР:** “Нийслэлийн Эрүүл мэндийн газрын харьяа байгууллагуудын 2020 онд хэрэглэх эм, эмнэлгийн хэрэгсэл” нийлүүлэх-3  
**ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ДУГААР:** НХААГ-20/0004

**Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар нь** эрх бүхий тендерт оролцогчдоос “**Нийслэлийн Эрүүл мэндийн газрын харьяа байгууллагуудын 2020 онд хэрэглэх эм, эмнэлгийн хэрэгсэл**”-ийг нийлүүлэх тухай цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү эм, эмнэлгийн хэрэгслийн тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу.

Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө **50,000 /Тавин мянга/** төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **30 хоногийн** дотор хүчинтэй байна.

Тендер нь дараах багцаас бүрдэнэ: Үүнд:

**Багц №22:** Чихрийн шижингийн эсрэг болон дааврын эмүүд, НХААГ-20/0004-22

**Багц №27:** Төрөл бүрийн өвчинд хэрэглэгддэг шингэн болон тосон эмүүд, НХААГ-20/0004-27

**Багц №28:** Төрөл бүрийн өвчинд хэрэглэгддэг шингэн болон тосон эмүүд /Дотоодын үйлдвэр/, НХААГ-20/0004-28

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

Борлуулалтын хэмжээ: **Сүүлийн 2 жил буюу 2018, 2019 онуудын аль нэг жилийн борлуулалтын орлогын хэмжээ нь багц тус бүрийн төсөвт өртгийн 50%-аас багагүй байна.**

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: **Багц тус бүрийн төсөвт өртгийн 30%-аас багагүй байх.**

Сүүлийн хоёр жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг: **Сүүлийн 2 жил буюу 2018, 2019 оны аль нэг жилд багц тус бүрийн төсөвт өртгийн 30 хувиас багагүй, үнийн дүнтэй ижил төстэй эм, эмнэлгийн хэрэгсэл нийлүүлсэн байх.**

Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл ирүүлэх эсэх: **Шаардлагатай**

Монгол Улсын Эрүүл мэндийн яамнаас олгогддог:

Хүний эм, эмнэлгийн хэрэгсэл импортлох, ханган нийлүүлэх, худалдах тусгай зөвшөөрөл.

Хүний эм, эмнэлгийн хэрэгсэл үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл.

Тендерийн хамт дараах тендерийн баталгаа ирүүлнэ. Үүнд:

**Багц №22:** 3,400,000 /гурван сая дөрвөн зуун мянга/ төгрөг

**Багц №27:** 250,000 /хоёр зуун тавин мянга / төгрөг

**Багц №28:** 120,000 /нэг зуун хорин мянга / төгрөг

Цахим тендерт оролцогч цахим баталгаа гаргах эрх бүхий арилжааны банкаар цахим тендерийн баталгаа гаргуулна.

Тендерийг **2020 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 10 цаг 00 минутаас өмнө** системд ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2020 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 10 цаг 30 минутад** Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын 1012 тоот өрөөнд нээнэ. Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй.

Дотоодын давуу эрх тооцно.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Бага тойруу-15, Самбуугийн гудамж,**

**Нийслэлийн Засаг захиргааны 4 дүгээр байр, 10 дугаар давхар,**

**Нийслэлийн худалдан авах ажиллагааны газар,**

**Утас: 75757807**

**Цахим хаяг: [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn), [www.ub-procurement.mn](http://www.ub-procurement.mn)**

## ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо : 2020 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр

**ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН НЭР:** “Нийслэлийн Эрүүл мэндийн газрын харьяа байгууллагуудын 2020 онд хэрэглэх эм, эмнэлгийн хэрэгсэл нийлүүлэх-04”  
**ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ДУГААР:** НХААГ-20/0004-4

**Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар нь** эрх бүхий тендерт оролцогчдоос “**Нийслэлийн Эрүүл мэндийн газрын харьяа байгууллагуудын 2020 онд хэрэглэх эм, эмнэлгийн хэрэгсэл**”-ийг нийлүүлэх тухай цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү эм, эмнэлгийн хэрэгслийн тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу.

Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө **50,000 /Тавин мянга/** төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **30 хоногийн** дотор хүчинтэй байна.

Тендер нь дараах багцаас бүрдэнэ: Үүнд:

**Багц №32:** Бусад эмийн хэлбэрүүд, НХААГ-20/0004-32

**Багц №33:** Бусад эмийн хэлбэрүүд, НХААГ-20/0004-33

**Багц №37:** Судсаар тарьж хэрэглэх шингэнүүд, НХААГ-20/0004-37

**Багц №38:** Уургийн бэлдмэл, НХААГ-20/0004-38

**Багц №39:** Судсаар сэлбэх тарилгын шингэнүүд, НХААГ-20/0004-39

**Багц №40:** Давс, ус, хүчил, шүлтийн тэнцвэрт нөлөөлөх дуслын шингэнүүд, НХААГ-20/0004-40

**Багц №41:** Тарилгын бусад шингэнүүд, НХААГ-20/0004-41

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

Борлуулалтын хэмжээ: **Сүүлийн 2 жил буюу 2018, 2019 онуудын аль нэг жилийн борлуулалтын орлогын хэмжээ нь багц тус бүрийн төсөвт өртгийн 50%-аас багагүй байна.**

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: **Багц тус бүрийн төсөвт өртгийн 30%-аас багагүй байх.**

Сүүлийн хоёр жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг: **Сүүлийн 2 жил буюу 2018, 2019 оны аль нэг жилд багц тус бүрийн төсөвт өртгийн 30 хувиас багагүй, үнийн дүнтэй ижил төстэй эм, эмнэлгийн хэрэгсэл нийлүүлсэн байх.**

Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл ирүүлэх эсэх: **Шаардлагатай**

Монгол Улсын Эрүүл мэндийн яамнаас олгогддог:

Хүний эм, эмнэлгийн хэрэгсэл импортлох, ханган нийлүүлэх, худалдах тусгай зөвшөөрөл.

Хүний эм, эмнэлгийн хэрэгсэл үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл.

Тендерийн хамт дараах тендерийн баталгаа ирүүлнэ. Үүнд:

**Багц №32:** 730,000 /Долоон зуун гучин мянга/ төгрөг

**Багц-№33** 1,200,000 /Нэг сая хоёр зуун мянга/

**Багц-№37** 570,000 /Таван зуун далан мянга/

**Багц-№38** 440,000 /Дөрвөн зуун дөчин мянга/

**Багц-№39** 3,500,000 /Гурван сая таван зуун мянга/

**Багц-№40** 4,300,000 /Дөрвөн сая гурван зуун мянга/

**Багц-№41** 1,100,000 /Нэг сая нэг зуун мянга/

Цахим тендерт оролцогч цахим баталгаа гаргах эрх бүхий арилжааны банкаар цахим тендерийн баталгаа гаргуулна.

Хүчинтэй байх хугацаа: **2020 оны 06 дугаар сарын 17-ны өдрийг дуустал** хүчинтэй байна.

Тендерийг **2020 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 11 цаг 00 минутаас өмнө** системд ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2020 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 11 цаг 10 минутад** Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын 1012 тоот өрөөнд нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй.

Дотоодын давуу эрх тооцно.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Бага тойруу-15, Самбуугийн гудамж,**

**Нийслэлийн Засаг захиргааны 4 дүгээр байр, 10 дугаар давхар,**

**Нийслэлийн худалдан авах ажиллагааны газар,**

**Утас: 75757807 Цахим хаяг: [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn), [www.ub-procurement.mn](http://www.ub-procurement.mn)**

## ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо : 2020 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр

**ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН НЭР:** “Нийслэлийн Эрүүл мэндийн газрын харьяа байгууллагуудын 2020 онд хэрэглэх эм, эмнэлгийн хэрэгсэл” нийлүүлэх-2  
**ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ДУГААР:** НХААГ-20/0004

**Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар нь** эрх бүхий тендерт оролцогчдоос “**Нийслэлийн Эрүүл мэндийн газрын харьяа байгууллагуудын 2020 онд хэрэглэх эм, эмнэлгийн хэрэгсэл-2**”-ыг нийлүүлэх тухай цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү эм, эмнэлгийн хэрэгслийн тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу.

Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө **50,000 /Тавин мянга/** төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **30 хоногийн** дотор хүчинтэй байна.

Тендер нь дараах багцаас бүрдэнэ: Үүнд:

**Багц №11:** Амин дэм, эрдэс бодисууд /Дотоодын үйлдвэр/, НХААГ-20/0004-11

**Багц №12:** Дааврын болон спазмолитик эмүүд, НХААГ-20/0004-12

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

Борлуулалтын хэмжээ: **Сүүлийн 2 жил буюу 2018, 2019 онуудын аль нэг жилийн борлуулалтын орлогын хэмжээ нь багц тус бүрийн төсөвт өртгийн 50%-аас багагүй байна.**

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: **Багц тус бүрийн төсөвт өртгийн 30%-аас багагүй байх.**

Сүүлийн хоёр жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг: **Сүүлийн 2 жил буюу 2018, 2019 оны аль нэг жилд багц тус бүрийн төсөвт өртгийн 30 хувиас багагүй, үнийн дүнтэй ижил төстэй эм, эмнэлгийн хэрэгсэл нийлүүлсэн байх.**

Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл ирүүлэх эсэх: **Шаардлагатай**

Монгол Улсын Эрүүл мэндийн яамнаас олгогддог:

Хүний эм, эмнэлгийн хэрэгсэл импортлох, ханган нийлүүлэх, худалдах тусгай зөвшөөрөл.

Хүний эм, эмнэлгийн хэрэгсэл үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл.

Тендерийн хамт дараах тендерийн баталгаа ирүүлнэ. Үүнд:

**Багц-№11:** 1,100,000 /Нэг сая нэг зуун мянга/ төгрөг

**Багц-№12:** 1,210,000 /Нэг сая хоёр зуун арван мянга/ төгрөг

Цахим тендерт оролцогч цахим баталгаа гаргах эрх бүхий арилжааны банкаар цахим тендерийн баталгаа гаргуулна.

Хүчинтэй байх хугацаа: **2020 оны 06 дугаар сарын 17-ны өдрийг дуустал** хүчинтэй байна.

Тендерийг **2020 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 09 цаг 00 минутаас өмнө** системд ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2020 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 09 цаг 40 минутад** Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын 1012 тоот өрөөнд нээнэ. Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй.

Дотоодын давуу эрх тооцно.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Бага тойруу-15, Самбуугийн гудамж,**

**Нийслэлийн Засаг захиргааны 4 дүгээр байр, 10 дугаар давхар,**

**Нийслэлийн худалдан авах ажиллагааны газар,**

**Утас: 75757807**

**Цахим хаяг: [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn), [www.ub-procurement.mn](http://www.ub-procurement.mn)**



О.Баярхүү, судлаач проф.

**М**онголчууд ер нь ямар их нэхэл хатуутай улс вэ, тэгэхдээ шал хэрэггүй юман дээр шүү хэмээн гадаадын нэгэн нөхөр надад доточлон ярьж байв. Аль ч асуудал дээр гонгинуур талдаа. Монгол-Хятадын хамтын ажиллагаанд манайхан л гонгинож, болохгүй бүтэхгүй асуудал үүсгэчихдэг тухай Гадаад харилцааны сайд ярьсныг бас тодхон санаж байна.

Эрүүл мэндээ сүйтгэж явж, явчихаад эргээд эрүүл мэндээ эмч, эмнэлэг, аптекаас бүр хилэгнэн нэхэн гээч. Эрүүл мэндийн сайдыг хүртэл огцруулахдаа тултал нэхнэ. Эрдэм ном сурахгүй сул дэл явж, явчихаад гуриатаад, ядуураад, золбирууд (ажлын ямар ч байранд тэнцэхгүй) ирэхийн цагт тэр баясгалант амьдралаа төр-засгаасаа огцортол нэхнэ. “Би ядуурчихлаа, хэн нэгэн л буруутай” гэмэгц улс төр нь тоглолт хийнэ.

**ТЭНГЭРИЙН ХИШГИЙН ҮЛГЭР ЦААШ НЭХЭЛ ДАГУУЛАН ХӨВӨРНӨ. АРДЫН ХУВЬСГАЛЫН ЖИЛҮҮД, СОЦИАЛИСТ МОНГОЛ БОЛ ТЭР ЧИГТЭЭ АЛТАН МОСКВАГИЙН ТЭНГЭРИЙН ХИШИГТ АМЬ НАС, ҮР ХҮҮХЭД, УЛС ГЭРЭЭ ДААТГАСАН 70 ЖИЛ.**

“Хэний төлөө Та амьдарч байгаа вэ” гэдэг нэхэл хатуу асуултыг харин сөргүүлж тавимаар. Хэвлэл мэдээллээр гардаг гонгинуур шүүмжүүдийг аваад үзвэл яг тийм асуулт тавиад, хариултыг газар дээр нь нэхмээр санагддаг. Энэ бол миний нэхэл шүү!

“Элбэгдоржийн хар дарсан найман жил”-ийн тухай аймшгийн үлгэр одоо ид цэцэглэж байна. Тэрээр найман жил Ерөнхийлөгч байсан нь үнэн, гэхдээ ард түмний хоёр удаагийн сонголтоор гарсан. Тэр үед УИХ үүргээ зүв зүгээр гүйцэтгэж, хоёр том нам парламентад шийдвэр гаргаж байлаа. С.Баяр, Сү.Батболд, Н.Алтанхуяг, Ч.Сайханбилэг, Ж.Эрдэнэбатын Засгийн газрууд хэвийн ажиллаж байлаа. УИХ-ын гурван ч спикер болох Д.Дэмбэрэл, З.Энхболд, М.Энхболд нар УАБЗ-д тэрхүү

“хар дарсан найман жил”-ийн ихэнхэд нь хамтран ажиллаж, шийдвэр гаргаж байлаа. “Хар дарсан найман жил”-д УАБЗ-ийг хамтран бүрдүүлж байсан найман эрхмийг би нэрлэчихлээ.

Түүний “идэж уусан”-ыг шүүх тогтоогоод ял өгөхийг би үгүйсгэх гээгүй. Тэрээр цэргийн эргэлт хийгээгүй, фашист дэглэм

өөрийнхөө төлөө, гэр бүл үр хүүхдийнхээ төлөө хөдөлмөрлөж хэвтэхгүй, өрөөл бусдаас тэнгэрийн хишиг горьдож, суусан нь хохь юм биш үү. Тэр найман жилд (2009-2017 он) ажлын байр хэдэн зуу, мянгаараа, сонин хэвлэл ажлын байрны зард дарагдчихсан байж байсан. Тэгтэл тэнгэрийн хишигт найдаад

хөдөлмөрлөсөн. Одоогийн өндөрлөгөөс ажвал удаан, үр бүтээл багатай, орос ах нарт чихдүүлж, тэнэг малаараа дуудуулан байж хөдөлмөрлөсөн он жилүүд шүү дээ. Зөвлөлт улс тарсан, зөвлөлтийн зээл тусламж зогссон, мэргэжилтэн ба цэргүүд нь нутаг буцав. Манай эдийн засаг ч хөмөрсөн.

**нэхлийг ёстой гааруулаа.** Тэнгэрийн хишгийн бороо орсон сонгуулиуд шил дарна. Сонгуульд үзэл санаа, мөнгө, нетворк сүлжээ ялдаг бол манайхан мөнгө ба шил архиар сонгогчдыг авлигадаж, өвчин болголоо. Дээр нь овоолчихсон нөгөө чанарууд – шударга, эх оронч гэх мэт пайзаа тэр бэлгэн дээрээ наачихна. Ялуулж гэсэн нэхэл, ялсныхаа дараа тийм тийм юм өг гэсэн нэхэл хоёр талаас уулзана.

Гэнэтхэн бороо оруулчихад л ялалт хүрээд ирнэ. Гэхдээ хэт их бороо оруулж, байнга тойргоо услаад байвал залхалт гээч нэг үзэгдэл бас дагалдана. Популист халамж популист бэлгээр амьдрал нь сайжрахгүй байгаа учраас нэг л өдөр цаад сонгогч гэрэвшчихнэ. Монгол хүн гэрэвшхээрээ буруу харсан ац л гэсэн үг. Нүүдэлчдэд гэрэвшил их садаа болдог.

Энэ олон сонгуулийн дараа ганц л бодит үнэн үлдэнэ. Дөрөв, дөрвөн жилд сонгуулийн дараа ирсэн Засгийн газар болгон бөөн болохгүй бүтэхгүй, мөнгөгүй, төсөвгүй, ядуус нь дэндчихсэн, эдийн засаг нь ямагт эмзэг, зээлтэй өртэй улс орныг хүлээн авна. Төсөв улайсан, үргэлж мөнгөний гачлантай, хэзээ ч мөнгө байдаггүй. Тэр асуудлаа шийдэж чадахгүй дөрвөн жил ухнатна. Дараагийн сонгуульд тэсэж гарахын тулд (очих газар нь нэгэнт тодорхой хүмүүсийн эцсийн тулалдааны сонгууль) популист халамжийн бороо оруулна.

Ердөө ганц теором: Нэг удаа авлаа, идлээ, уулаа, дууслаа. Дараагийнхыг нэхлээ, дахиад нэг удаа авлаа, идлээ, уулаа, дууслаа. Цаг наргүй үргэлжилж байх ёстой мэтээр өнөө цагийн монголчуудад гүн суужээ. Ажил төрөл эрхлэх сэтгэхүй нь нэхэлтэйгээ холилдоод алга боллоо. Ганц үр дүн гэвэл, төр засгаа 30 жил хараагаад сууж байна.


Нийслэлийн Баянзүрх, Сонгинохайрхан гэж хоёр дүүрэг тэнгэрийн хишгийн бороо оруулдаг буянтай тойргууд байна аа гэмэгц хөдөөгийн бэлэнчлэгчид хот руу хуйлраад энэ хотыг нураах дээрээ тулчихаад байна.

Сайн малчны яриа: Манай сумынхан цөөрсөн. Манай сумын хамаг залуучууд Улаанбаатар руу нүүгээд алга болсон, мал маллахаасаа залхуураад.

